


САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН 2015 ОНЫ II УЛИРЛЫН НЭГДСЭН ТОЙМ

/Банкнаас бусад салбар/



УЛААНБААТАР 2015

I БҮЛЭГ: ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ	5
II БҮЛЭГ: МАКРО ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ОРЧИН	6
2.1 Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	6
Макро эдийн засгийн нөхцөл байдал:	6
Дотоодын нийт бүтээгдэхүүн:	6
Банкны салбар:	6
Улсын төсөв:	7
Гадаад худалдаа, төлбөрийн баланс:	7
Гадаадын шууд хөрөнгө оруулалт:	7
Хэрэглээний үнийн индекс:	7
III БҮЛЭГ: ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ	8
3.1. Үнэт цаасны зах зээлийн хөгжлийн үндсэн үзүүлэлтүүд:	8
Үнэт цаасны арилжаа: Тайлант хугацаанд	8
Засгийн газрын үнэт цаасны арилжаа:	8
Зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадвар:	9
Топ-20 болон MSE ALL индекс:	9
3.2. Үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдын бүтэц:	10
Хөрөнгө оруулагчдын бүтэц:	11
3.4. Мэргэжлийн зуучлагч байгууллага:	12
IV БҮЛЭГ: ДААТГАЛЫН САЛБАРЫН ТОЙМ	16
4.1. Даатгалын салбарын статистик үзүүлэлтүүд:	16
4.2. Даатгалын салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээ:	18
4.3. Даатгалын салбарын хөгжлийн үзүүлэлтүүд:	19
Даатгалын гүнзгийрэлт.....	Error! Bookmark not defined.
Даатгалын нягтрал	20
Зохистой харьцааны үзүүлэлтүүд.....	21
V БҮЛЭГ: БИЧИЛ САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОЙМ	22
5.1. Бичил санхүүгийн салбарын өнөөгийн байдал:	22
5.2. Банк бус санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид:	22
5.3. Банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн үзүүлэлт:	23
Активын үзүүлэлтүүд:	23
Зээлийн үзүүлэлт:	25
5.4. Банк бус санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааны үзүүлэлт:	25
5.5. Хадгаламж зээлийн хоршооны өнөөгийн байдал	26
5.6. Хадгаламж зээлийн хоршоод, тэдгээрийн үндсэн үзүүлэлтүүд:	27
Хадгаламж зээлийн хоршоодын зээлийн үзүүлэлтүүд:	28
Хадгаламж зээлийн хоршоодын хадгаламжийн үзүүлэлтүүд:	28
5.7 Зээлийн батлан даалтын сан	29

6.1. Үнэт цаасны зах зээл: 31

6.2. Даатгалын салбар: 31

6.3. Бичил санхүүгийн салбар:..... 31

7.1. Зохицуулалттай салбарыг хөгжүүлэх чиглэлээр: 32

7.2. Нэгдсэн бодлого, зохицуулалтын чиглэлээр:..... 34

**Хавсралт 1. Үнэт цаасны зах зээлийн хувьцаат компани болон мэргэжлийн
оролцогчдын 2015 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэл..... 35**

1. Хувьцаат компанийн санхүүгийн байдал.....35
2. Хувьцаат компанийн орлого, үр дүн36
3. Үнэт цаасны компаниудын санхүүгийн байдал37
4. Үнэт цаасны компаниудын орлого, үр дүн38

**Хавсралт 2. Хөдөө аж ахуйн биржийн мэргэжлийн оролцогчдын 2015 оны 2 дугаар
улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэл 39**

1. Санхүүгийн байдлын тайлан.....39
2. Орлого, үр дүнгийн тайлан.....41

**Хавсралт 3. Даатгалын компаниудын 2015 оны 2 дугаар улирлын санхүүгийн
тайлангийн нэгтгэл..... 42**

1. Санхүүгийн байдлын тайлан /мянган төгрөг/.....42
2. Ердийн даатгалын компаниудын орлого, үр дүнгийн тайлан /мянган төгрөг/.....43
3. Урт хугацаат даатгалын компаниудын орлого, үр дүнгийн тайлан /мянган төгрөг/45

**Хавсралт 4. Банк бус санхүүгийн байгууллагын 2015 оны 2 дугаар улирлын санхүүгийн
тайлангийн нэгтгэл..... 47**

1. Санхүүгийн байдлын тайлан /мянган төгрөг/.....47
2. Орлого, үр дүнгийн тайлан /мянган төгрөг/51

**Хавсралт 5. Хадгаламж зээлийн хоршоодын 2015 оны 2 дугаар улирлын санхүүгийн
тайлангийн нэгтгэл..... 53**

1. Санхүүгийн байдлын тайлан /мянган төгрөг/.....53
2. Орлого, үр дүнгийн тайлан.....55

ХҮСНЭГТҮҮД

- Хүснэгт-1 Зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадвар
- Хүснэгт-2 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас
- Хүснэгт-3 Үнэт цаас гаргагч компанийн хэлбэр
- Хүснэгт-4 Компанийн засаглалын үзүүлэлтүүд
- Хүснэгт-5 Хөрөнгө оруулагчдын бүтэц
- Хүснэгт-6 Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогч
- Хүснэгт-7 Үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэгч байгууллага
- Хүснэгт-8 ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн зах зээлийн арилжаа
- Хүснэгт-9 Даатгалын салбарын тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигч
- Хүснэгт-10 Даатгалын салбарын үйл ажиллагааны үзүүлэлтүүд
- Хүснэгт-11 Даатгуулагчийн тоо, нөхөн төлбөрийн хэмжээ
- Хүснэгт-12 Ердийн даатгалын хураамжийн орлого
- Хүснэгт-13 Урт хугацаат даатгалын хураамжийн орлого
- Хүснэгт-14 Даатгалын гүнзгийрэлт
- Хүснэгт-15 Даатгалын нягтрал
- Хүснэгт-16 Даатгалын салбарын зохистой харьцаа
- Хүснэгт-17 ББСБ-ын тоо
- Хүснэгт-18 ББСБ-ын эргэлтийн хөрөнгийн бүтэц
- Хүснэгт-19 Банк бус санхүүгийн байгууллагын бүтэц
- Хүснэгт-20 Хадгаламж зээлийн хоршоодын үндсэн үзүүлэлт
- Хүснэгт-21 Зээлийн батлан даалт олгосон байгууллагууд

ГРАФИКУУД

- График-1 Үнэт цаасны арилжаа
- График-2 Хувьцааны арилжаа
- График-3 ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн зах зээлийн арилжаа
- График-4 Даатгалын хураамжийн орлого төвлөрүүлэлт
- График-5 Даатгалын компаниудын нийт хөрөнгө
- График-6 Даатгалын гүнзгийрэлт
- График-7 Даатгалын нягтрал
- График-8 Банк бус санхүүгийн байгууллагын актив
- График-9 Банк бус санхүүгийн байгууллагын нийт активын өсөлт
- График-10 Банк бус санхүүгийн байгууллагын нийт активын бүтэц
- График-11 Банк бус санхүүгийн байгууллагын нийт зээл, зээлийн багц
- График-12 Хадгаламж зээлийн хоршоодын нийт зээлийн хэмжээ
- График-13 Хадгаламж зээлийн хоршоодын хадгаламжийн өөрчлөлт
- График-14 Хадгаламж зээлийн хоршоодын нийт ашигт ажиллагаа
- График-15 Зээлийн батлан даалтын мэдээ

I БҮЛЭГ: ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Нэгдсэн үндэстний байгууллагаас¹ гаргасан 2015 оны дэлхийн эдийн засгийн төлвийн талаарх тоймд ихэнх орнуудын эдийн засаг хямралын өмнөх үетэй харьцуулахад бага хэмжээгээр өсч, урт хугацаанд дундаж өсөлттэй байх бөгөөд дэлхийн нийт бүтээгдэхүүний бодит хэмжээ 2015 онд 3.1, 2016 онд 3.3 хувиар тус тус өсөх төлөвтэй байна.

Ажил эрхлэлтийн түвшин: Хөгжингүй орнуудад ажилгүйдлийн түвшин өндөр хэвээр, харин хөгжиж буй эдийн засагтай орнуудад хөдөлмөр эрхлэлт 2013 оноос хойш аажмаар өсч байна.

Инфляци: Дэлхийн хэмжээнд инфляцийн түвшинг өмнөх 2 жилийн байдалтай ижил буюу 3 орчим хувьтай байхаар таамаглаж байна. Хөгжсөн эдийн засагтай орнуудын инфляци 2016 он хүртэл аажмаар өсч, харин шилжилтийн болон хөгжиж байгаа эдийн засагтай орнуудын инфляци буурах төлөвтэй байна.

Олон улсын худалдаа: Олон улсын худалдаа 2015 онд 3.4, олон улсын бараа, үйлчилгээний импортын хэмжээ 2015 онд 4.7, 2016 онд 5 хувиар тус тус өсөх хандлага ажиглагдаж байна. Гэвч олон улсад түүхий эдийн үнэ буурах хандлагатай буюу газрын тосны үнэ 2014 оны сүүлийн хагас жилд огцом буурсан ба 2015, 2016 онуудад үргэлжлэх төлөвтэй байна. Мөн газрын тосноос бусад түүхий эдийн хувьд сүүлийн арван жилийн хандлага хэвээр байгаа ч үнийн түвшин буурч байна.

Шигтгээ 1:

АНУ-ын хөдөлмөрийн зах зээлийн тэлэлт цаашидаа үргэлжлэх хандлагатай, мөнгөний бодлогыг тогтворжуулах процессыг хэрэгжүүлж эхэлж байна. Европын бүсэд санхүүгийн хямралыг даван туулсаар байна. АНУ, Европын хөгжингүй орнууд банкны зээлээс зах зээлд суурилсан санхүүгийн зах зээл рүү аажмаар шилжиж байна. Тухайлбал, корпорацийн бонд банкны зээлээс илүү их арилжаалагдаж байна.

Япон улс шинэ мөнгөний бодлого хэрэгжүүлж, эдийн засгийн огцом өсөлтийг бий болгоод байна.

Хятад улс одоог хүртэл дэлхийн эдийн засгийн гол хөдөлгүүр улс хэвээр боловч эдийн засгийн удааширалттай холбоотой эрх баригчдын зүгээс эдийн засгийн хөгжлийн загварыг өөрчлөх, хөрөнгийн зах зээлийн уналтын эсрэг тэтгэврийн сангийн хөрөнгийг зах зээлд татан оруулах зэрэг арга хэмжээг авч эхэлжээ.

Сингапурын төв банкнаас 2014 оны тайландаа дэлхийн эдийн засаг санхүүгийн хямралыг аажмаар даван туулж шинэ шатанд хүрсэн гэж дүгнэжээ.

Азийн бусад орнуудын хувьд энэ жил санхүүгийн хүнд нөхцөл байдалтай, улс төрийн байдал тодорхойгүй хэдий ч экспортоос бага зэрэг өгөөж хүртэхээр байна.

¹ World economic situation and prospects 2015

II БҮЛЭГ: МАКРО ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ОРЧИН

2.1 Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд²

Макро эдийн засгийн нөхцөл байдал:

Азийн хөгжлийн банкнаас Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2015 онд 3 хувь, Олон улсын валютын сангаас 4.4 хувийн өсөлттэй байна гэж тус тус таамагласан. 2015 оны эхийн хагас жилийн байдлаар Монгол улсын эдийн засгийн өсөлт Үндэсний статистикийн хорооноос тооцоолсоноор 3 хувьтай гарсан бөгөөд ирэх жилүүдэд уул уурхайн бүтээгдэхүүний экспортын бууралттай холбоотойгоор тус салбарын үйлдвэрлэлийн хэмжээ багасч, урсгал дансны алдагдал нэмэгдэн, гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ төдийлөн сэргэх төлөвгүй байгаа тул төсвийн тэлэх бодлогыг хязгаарлах шаардлага үүсээд байна.

Монгол Улсын эдийн засгийн тогтвортой орчинг бий болгох, эдийн засгийн өсөлтийг сайжруулахад санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх шаардлагатай ба ингэснээр урт хугацаанд нийгэм, эдийн засагт үр ашгаа өгөх, томоохон төслүүдийг хөрөнгийн зах зээлээр дамжуулан санхүүжүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Хорооны зүгээс Монгол Улсын макро эдийн засгийг дэмжиж, санхүүгийн зах зээлийг олон тулгуурт, үр ашиг бүхий тогтолцоонд хүргэх зорилгоор “Монгол Улсын санхүүгийн зах зээлийн 2020 он хүртэлх хугацааны шинэчлэл хөгжлийн хөтөлбөр”-ийн төслийг боловсруулж, 2015-2020 оны хооронд хоёр үе шаттайгаар хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Дотоодын нийт бүтээгдэхүүн:³ 2015 оны эхний хагас жилийн байдлаар Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит хэмжээг 2010 оны зэрэгцүүлэх үнээр тооцоход 4201.2 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 88.3 тэрбум төгрөг буюу 2.14 хувиар өссөн байна. Дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 2015 оны эхний хагас жилд 10690.0 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 771.3 тэрбум төгрөг буюу 7.2 хувиар өсчээ. Дотоодын нийт бүтээгдэхүүний өөрчлөлтөд хөдөө аж ахуй, уул уурхай болон үйлчилгээний салбарын өсөлт нөлөөлөв.

Банкны салбар: Мөнгөний нийлүүлэлт (M2) 2015 оны 6 дугаар сарын эцэст 10 их наяд төгрөг болж, өмнөх сараас 2 хувиар өсч, харин өмнөх оны мөн үеэс 0.65 хувиар буурлаа. Мөнгөний нийлүүлэлтэд эзлэх M1 мөнгө 16.9, төгрөгийн хадгаламж 53.7, гадаад валютын хадгаламж 20.5, түүний харилцах 10.82 хувьтай байна.

Арилжааны банкны зээлийн үлдэгдэл 2015 оны 2 дугаар улирлын байдлаар 11.9 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд үүнд хэвийн зээл 88.47, хугацаа хэтэрсэн зээл 5.05, чанаргүй зээл 6.48 хувийг тус тус эзэлж байна.

Банкны системийн хэмжээгээр хугацаа хэтэрсэн зээл 603.9 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 3.3 тэрбум төгрөгөөр буюу 0.6, өмнөх оны мөн үеэс 165.6 тэрбум төгрөгөөр буюу 37.8 хувиар тус тус өссөн байна.

Чанаргүй зээл 773.9 тэрбум төгрөг болж, өмнөх сарынхаас 34.9 тэрбум төгрөг буюу 4.8 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 207.0 тэрбум төгрөг буюу 36.5 хувиар өссөн байна.

Тайлант хугацаанд нийт хадгаламжийн үлдэгдэл 7.31 их наяд төгрөг, үүнээс 5.3 их наяд төгрөг нь төгрөгийн хадгаламж, 2.02 их наяд төгрөг нь валютын хадгаламж тус тус эзэлж байна. Төгрөгийн хадгаламжийн жигнэсэн жилийн дундаж хүү 12.9 хувь, харин валютын жигнэсэн жилийн дундаж хүү 6.3 хувь байна. Нийт төгрөгийн хадгаламжийн 77 хувийг иргэд, 23 хувийг аж ахуй нэгж байгууллагын хадгаламж тус тус эзэлж байна.

²Эх үүсвэр: Монгол банк

Үндэсний статистикийн хороо

³ДНБ-ийг үйлдвэрлэлийн аргаар тооцсон тоон мэдээллийг ашиглав.

Банкнаас бусад санхүүгийн салбар: Зах зээлийн үнэлгээ 1.41 их наяд төгрөгт хүрч, энэ оны өмнөх улирлаас 97.4 тэрбум төгрөгөөр буюу 7.4 хувиар өссөн байна. 2015 оны эхний хагас жилийн байдлаар 125 удаагийн арилжаагаар 105 компанийн 16.4 сая ширхэг хувьцааг 5.7 тэрбум төгрөгөөр, ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн 25 удаагийн арилжаагаар 2.9 сая ширхэг үнэт цаасыг 283.4 тэрбум төгрөгөөр, ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 15.1 мянган ширхэг үнэт цаасыг 1.5 тэрбум төгрөгөөр тус тус арилжиж, нийт 290.6 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгджээ.

2015 оны 2 дугаар улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж буй даатгалын болон давхар даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 170.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 33.9 тэрбум төгрөгөөр буюу 27.8 хувиар өссөн байна. Нөхөн төлбөрийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.4 тэрбум төгрөгөөр буюу 15.4 хувиар өслөө.

2015 оны эхний хагас жилийн байдлаар тусгай зөвшөөрөл бүхий 423 банк бус санхүүгийн байгууллагууд нийт 554.5 тэрбум төгрөгийн актив хөрөнгөтэй байгаа ба нийт зээлийн багцын үлдэгдлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 92.0 тэрбум төгрөгөөр буюу 34 хувиар нэмэгдэж, нийт зээлийн багцад эзлэх хугацаа хэтэрсэн зээл 0.5 хувиар буурсан бол чанаргүй зээлийн эзлэх хувь 1.1 дахин өссөн байна.

Хадгаламж зээлийн хоршоодын нийт активын хэмжээ 85.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 11.4 хувиар нэмэгдсэн байна. Тайлант хугацаанд нийт зээлийн үлдэгдлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.3 тэрбум төгрөг буюу 13.8 хувиар өссөн бол чанаргүй зээлийн үлдэгдэл 0.42 тэрбум төгрөг буюу 23.4 хувиар өсчээ. Хадгаламж зээлийн хоршоодын нийт зээлийн багц 70.8 тэрбум төгрөг байгаа нь нийт активын 82.7 хувьтай, нийт зээл 68.9 тэрбум төгрөг байгаа нь нийт активын 80.5 хувьтай тус тус тэнцэж байна.

Тайлант хугацаанд татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 55.8 тэрбум төгрөг буюу нийт эх үүсвэрийн 65.2 хувийг эзэлж байгаа бөгөөд үүний 54.5 тэрбум төгрөг буюу 97.6 хувь нь 12094 гишүүний хугацаатай хадгаламж байгаа бол 1.3 тэрбум төгрөг буюу 2.4 хувь нь 3736 гишүүний хугацаагүй хадгаламж байна.

Улсын төсөв: 2015 оны эхний хагас жилд улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2640.2 тэрбум төгрөг, зарлага болон эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 3175.0 тэрбум төгрөг болж, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 534.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеийнхээс 294.2 тэрбум төгрөгөөр өсөхөд зарлагын өсөлт нь орлогын өсөлтөөс 10.2 пунктээр илүү байгаа нь нөлөөлжээ.

Гадаад худалдаа, төлбөрийн баланс: Гадаад худалдааны тэнцэл 2014 оны 2 дугаар улиралд 156.1 сая ам.долларын алдагдалтай байсан бол тайлант хугацаанд 531.4 сая ам.долларын ашигтай гарчээ. Экспортын хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 109.8 сая ам.доллар буюу 4.4 хувиар буурсан бөгөөд үүнд эрдэс бүтээгдэхүүн болон нэхмэл бүтээгдэхүүний экспортын бууралт голлон нөлөөлжээ.

2015 оны эхний 6 дугаар сарын гүйцэтгэлээр Монгол улсын төлбөрийн тэнцэл 83.2 сая ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 185.9 сая ам.доллараар алдагдал нь буурсан байна. Дансдын хувьд Урсгал данс 216 сая ам.долларын алдагдалтай, хөрөнгө ба санхүүгийн тэнцэл 236.9 сая ам.долларын ашигтай байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт: Гадаадын шууд хөрөнгө оруулалт 2015 оны 2 дугаар улирлын байдлаар 155.6 сая ам.долларт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 71.7 сая ам.доллар буюу 85.4 хувиар өссөн.

Хэрэглээний үнийн индекс:


Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ улсын хэмжээнд 2015 оны 6 дугаар сард өмнөх сарынхаас 0.1 хувиар буурч, оны эхнээс 3.2 хувиар өслөө.

III БҮЛЭГ: ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

3.1. Үнэт цаасны зах зээлийн хөгжлийн үндсэн үзүүлэлтүүд:

Үнэт цаасны арилжаа: Тайлант хугацаанд хувьцааны анхдагч зах зээл дээр 112 сая төгрөг, хоёрдогч зах зээлд 5.7 тэрбум төгрөг, ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр 283.4 тэрбум төгрөг, хоёрдогч зах зээлд 1.5 тэрбум төгрөгийн арилжаа явагдаж, нийт 290.6 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдлээ.

График 1. Үнэт цаасны арилжаа




Засгийн газрын үнэт цаасны арилжаа: Тайлант хугацаанд ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжааны 89.05 хувийг 12 долоо хоногтой, 5.64 хувийг 28 долоо хоногтой, 5.3 хувийг 52 долоо хоногтой, 0.01 хувийг 3 болон 5 жилийн урт хугацаатай үнэт цаас тус тус эзлэв.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжааг идэвхжүүлэх үүднээс итгэмжлэгдсэн дилерийн тогтолцоог нэвтрүүлснээр 4 үнэт цаасны компани нийт 1.5 тэрбум төгрөгийн гүйлгээг хийв.

Хувьцааны арилжаа: Тайлант хугацаанд 13 удаагийн багцын арилжаагаар нийт 13 компанийн 11.1 сая ширхэг хувьцааг 1.5 тэрбум төгрөгөөр арилжсан нь нийт арилжааны үнийн дүнгийн 26.78 хувийг эзэлжээ. Мөн нэг удаагийн тендер саналын арилжаа явагдаж, 202 ширхэг хувьцааг 711.4 мянган төгрөгөөр арилжсан байна.

График 2. Хувьцааны арилжаа



Зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадвар: Зах зээлийн үнэлгээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 163.8 тэрбум төгрөгөөр буюу 10.41 хувиар буурсан боловч, энэ оны өмнөх улирлаас 97.4 тэрбум төгрөгөөр буюу 7.4 хувиар өсч, нийтдээ 1408.5 тэрбум төгрөг болсон байна. Үнэлгээ өндөр 30 компани нийт зах зээлийн үнэлгээний 88.71 хувийг эзэлж байна. Хөрвөх чадварын түвшин 0.4 хувь байгаа нь хувьцааны арилжаа зогсонги, эргэц муутайг илтгэж байна.

Хүснэгт 1. Зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадвар

Д/Д	Зах зээлийн үнэлгээ /тэрбум ₮/	ДНБ /тэрбум ₮/	ЗЗҮ/ДНБ /хувиар/	Хөрвөх чадвар	Арилжааны хэмжээ /сая ₮/
2007/II	252.8	2,157.4	11.72	0.12	30.8
2008/II	809.7	2,937.5	27.56	0.06	45.04
2009/II	47.4	2,810.2	16.77	0.02	10.3
2010/II	768.4	1,674.6	45.89	0.02	15.2
2011/II	1,991.1	5,989.8	33.24	0.04	82.3
2012/II	1,895.2	7,735.8	24.50	0.03	61.2
2013/II	1,437.7	8,585.4	16.75	0.01	12.3
2014/II	1,572.4	9,918.8	15.85	0.01	12.9
2015/II	1,408.5	10,690.0	13.17	0.004	5.7

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо
Монголын хөрөнгийн бирж

Тайлант хугацаанд нийт 105 компанийн үнэт цаас арилжигдсанаас өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32 компанийн үнэт цаасны ханш өсч, 57 компанийн үнэт цаасны ханш буурч, 12 компанийн үнэт цаасны ханш тогтмол байв.

Топ-20 болон MSE ALL индекс: Тайлант хугацаанд ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 15737.17, доод үзүүлэлт 12981.92, дундаж үзүүлэлт 14591.23 нэгж байв. ТОП-20 индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 665.33 нэгжээр буюу 4.36 хувиар буурсан боловч энэ оны өмнөх улирлаас 1495.46 нэгжээр буюу 11.4 хувиар өссөн байна.

MSE ALL индексийн дээд үзүүлэлт 1057.86, доод үзүүлэлт 931.22, дундаж үзүүлэлт 1004.62 нэгжид хүрч энэ оны өмнөх улирлын дунджаас 4.8 хувиар өслөө.

Шигтгээ-2:

Засгийн газрын үнэт цаасны өгөөж өндөр байгаа нь хувьцааны эрэлтэд сөргөөр нөлөөлөв.

2015 оны 6 дугаар сард уул уурхайн салбарын компаниудын хувьцааны ханш 33.4, үйлдвэрлэлийн салбарын компаниудын хувьцааны ханш 4 хувиар нэмэгдсэн нь 2015 он гарснаас хойш буурч байсан зах зээлийн үнэлгээ, ТОП-20 болон MSE ALL индекс өсөхөд нөлөө үзүүлжээ.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас: Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын дагуу Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд “Монголын ипотекийн корпораци ОССК” ХХК нь 2015 оны эхний хагас жилийн байдлаар 5 удаагийн нийт 36,768 зээлдэгчийн зээлийн хөрөнгөөр баталгаажсан 1616.0 тэрбум төгрөгийн үнэ бүхий хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргаад байна.

Хүснэгт 2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас			
Үнэт цаас гаргагч	Нийт гаргасан баталгаат үнэт цаас /тэрбум төгрөг/	"ҮЦТТТХТ" ХХК-д бүртгэсэн үнэт цаас /тэрбум төгрөг/	Зээлдэгчдийн тоо /мянга/
“МИК актив нэг ТЗК” ХХК	328.1	322.9	7.9
“МИК актив хоёр ТЗК” ХХК	224.8	222.05	5.9
“МИК актив гурав ТЗК” ХХК	328.5	324.6	7.1
“МИК актив дөрөв ТЗК” ХХК	459.4	452.3	9.9
“МИК актив тав ТЗК” ХХК	301.2	294.3	5.9
Нийт	1642.00	1616.1	36.7

Эх сурвалж: “МИК ОССК” ХХК

3.2. Үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдын бүтэц:

Хүснэгт 3. Үнэт цаас гаргагч компанийн хэлбэр

Үнэт цаас гаргагчийн хэлбэр	Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй	“Монголын хөрөнгийн бирж” ХК-д бүртгэлтэй	“ҮЦТТТХТ” ХХК-д бүртгэлтэй
100% Төрийн өмчийн	32	19	19
Төрийн өмчийн оролцоотой	11	4	11
Орон нутгийн оролцоотой	15	9	15
Хувийн өмчийн	245	205	276
Нийт	303	237	321

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хорооны 2012 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам” болон Хорооны 2013 оны 505 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам”-аар хувьцаат компаниудад хүлээлгэсэн үүргийн хэрэгжилтийн байдал Хороонд бүртгэлтэй нийт 303 ХК-ийн хувьд 2015 оны эхний хагас жилийн байдлаар дараах байдалтай байна.

Хүснэгт 4. Компанийн засаглалын үзүүлэлтүүд

Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлээ ирүүлсэн компанийн тоо /Нийт 303 ХК/	Санхүүгийн тайлан ирүүлсэн компанийн тоо	Хувьцаа эзэмшигчдийн хурлаа хуралдуулсан компанийн тоо	Ногдол ашиг хуваарилсан компанийн тоо
145 ХК /47.85%/	177 ХК /58.41%/	133 ХК /43.89%/	23 ХК /7.59%/

Дээрхээс үнэт цаасны арилжаа нь зогссон 90, 100 хувийн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 15 хувьцаат компанийн хувьцаа “Монголын хөрөнгийн бирж” ХК дээр арилжаалагдахгүй байгаа болно.

Компанийн тухай хуулийн 31.3-г заасан компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассан хувьцаат компаниудын тоо 49 байх бөгөөд уг

СЗХ | Зохицуулалтын салбарын нэгдсэн тойм

хувьцаат компаниудын өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгөөс нийлбэр дүнгээр 131.8 тэрбум төгрөгөөр багассан үзүүлэлттэй байна.

Шигтгээ-3:

Бүртгэлтэй компаниудын хувьцаа хэт төвлөрснөөс компанийн засаглал, мэдээллийн ил тод байдал алдагдаж, хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт буурснаар, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хөндөгдөх нөхцөл үүсээд байна.

Хорооны зүгээс бүртгэлтэй компаниудын засаглалыг сайжруулах, төвлөрлийг бууруулах, бүртгэлийг цэгцлэх ажлын хүрээнд Хороо болон хөрөнгийн биржид бүртгэлтэй арилжаа нь зогссон, сүүлийн 3 ба түүнээс дээш жил үйл ажиллагаа явуулаагүй, хувьцаа эзэмшигчдийн өмнө хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй компаниудыг үе шаттайгаар бүртгэлээс хасах, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний нэвтрүүлэлтийг дэмжих, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх үүднээс нэмж үнэт цаас гаргах замаар төвлөрлийг сааруулах, хувьцаа хуваах зэрэг талаар зөвлөмж, шаардлага хүргүүлэх ажлыг зохион байгуулах, мөн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хуульд зааснаас багассан компаниудыг дахин хөрөнгөжүүлэх, татан буулгах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хөрөнгө оруулагчдын бүтэц: Тайлант хугацаанд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид шинээр 6842 данс нээгдсэнээс Монгол Улсын 6803 иргэн, гадаадын 22 иргэн, Монгол Улсын 16, гадаадын 1 аж ахуй нэгж шинээр данс нээлгэсэн байна. Төвлөрсөн хадгаламжид өссөн дүнгээр нийт 797403 данс нээгдсэнээс дотоодын иргэдийн 792980, гадаад иргэдийн 1793, дотоодын аж ахуйн нэгжийн 2456, гадаадын аж ахуйн нэгжийн 174 данс тус тус бүртгэлтэй байна.

2015 оны 2 дугаар улирлын байдлаар “ҮЦТТХТ” ХХК-д бүртгэлтэй 797.4 мянган данснаас зөвхөн 2369 харилцагчийн данс арилжаанд идэвхтэй оролцсон байх ба “Монголын хөрөнгийн бирж” ХК дээр Засгийн газрын үнэт цаас болон хувьцааны арилжаанд оролцсон хөрөнгө оруулагчдын бүтцийг үзүүлбэл дараах байдалтай байна.

Хүснэгт 5. Хөрөнгө оруулагчдын бүтэц

д/д	Хөрөнгө оруулагчдын бүтэц	Арилжааны үнийн дүн тэрбум төгрөг	Арилжаанд эзлэх хувь
1.	Гадаадын аж ахуйн нэгж	1.4	0.78
2.	Гадаадын иргэн	1.4	0.79
3.	Дотоодын аж ахуйн нэгж	168.9	94.42
4.	Дотоодын иргэн	7.2	4.01

Эх сурвалж: “ҮЦТТХТ” ХХК

Хувьцаат компанийн 5 хувиас дээш хувийг өмчлөгч нийт 1048 хувьцаа эзэмшигчийн эзэмшилд 19.3 тэрбум ширхэг хувьцаа төвлөрсөн байна. Энэ нь нийт бүртгэлтэй хувьцааны 96.7 хувийг эзэлж байна.

Шигтгээ-4:

Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг 50 мянга гаруй компани байдаг боловч урт хугацаат санхүүжилтийн эх үүсвэрээ үнэт цаасны зах зээлээс татах тогтолцоо хэвшээгүй.

Үнэт цаасны зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлт хязгаарлагдмал тул хөрвөх чадвар муу, гадаадын томоохон институциональ хөрөнгө оруулагчдын хөрөнгийг найдвартай хадгалах, хувьцаа эзэмшигчийн эрхээ гүйцэтгүүлэх кастодианы үйлчилгээ бүрэн нэвтрээгүй.

Мөн хөрөнгө оруулагчдыг дэмжсэн татварын хөнгөлөлтийн тогтолцоо байхгүй.

3.3. Үнэт цаасны зах зээлийн төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламж: 2015 оны 2 дугаар улирлын байдлаар төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн дансаар нийт 389 харилцагчийн дансанд 1666 удаагийн 1437.4 тэрбум төгрөгийн орлогын, нийт 1980 харилцагчийн 2638 удаагийн 1436.9 тэрбум төгрөгийн зарлагыг тус тус, нийт 2369 харилцагчийн дансанд 4304 удаа 2874.4 тэрбум төгрөгийн гүйлгээг хийжээ. Эхний хагас жилийн байдлаар “ҮЦТТХТ” ХХК-иар дамжуулан “Голомт” банк 1059.0 сая төгрөг, “Хаан” банк 51.3 сая төгрөг, “Хас” банк 1144.0 сая төгрөг, “Худалдаа хөгжлийн” банк 671.4 сая төгрөгийн үнэт цаасны мөнгөн төлбөрийг банк хоорондын гүйлгээгээр гүйцэтгэсэн байна.

3.4. Мэргэжлийн зуучлагч байгууллага:

2015 оны 2 дугаар улирлын байдлаар Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн оролцогчдыг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 6. Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогч

№	Тусгай зөвшөөрөл төрлөөр	Зохицуулалттай этгээдийн тоо
1	Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн тоо: Үүнээс	81
1.1	Үнэт цаасны арилжаа эрхлэх	1
1.2	Үнэт цаасны төлбөр, тооцоо, төвлөрсөн хадгаламж	1
1.3	Өөрийгөө зохицуулах байгууллага	1
1.4	Брокер	61
1.5	Дилер /давхардсан тоогоо/	59
1.6	Андеррайтер /давхардсан тоогоор/	25
1.7	Хөрөнгө оруулалтын зөвлөх /давхардсан тоогоор/	16
1.8	Хөрөнгө оруулалтын менежмент	3
1.9	Хөрөнгө итгэмжлэн удирдах	0
1.10	Төлбөр гүйцэтгэгч банк	5
1.11	Засгийн газрын үнэт цаас зуучлан борлуулах үйлчилгээ /банк/	10
1.12	Кастодиан банк	3
1.13	Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах	4

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Актив, пассивын бүтэц:2015 оны 2 дугаар улирлын байдлаар нэгтгэлд хамрагдсан 48 үнэт цаасны компаниудын нийт актив хөрөнгө 3719.5 тэрбум төгрөг бөгөөд нийт активт мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө 23.5, авлага 62.8, бараа материал, урьдчилж төлсөн зардал 0.01, богино хугацаат хөрөнгө оруулалт 8.81, бараа материал 0.05, үндсэн хөрөнгө 2.62, бусад үндсэн хөрөнгө 0.02, бусад эргэлтийн бус хөрөнгө 1.38 хувийг тус тус эзэлж байна.

Санхүүгийн тайлангийн нэгтгэлийн активын үзүүлэлтээс харахад, эргэлтийн хөрөнгө нийт активын 96.03 хувь, эргэлтийн бус хөрөнгө 3.97 хувийг тус тус эзэлж байна. Энэ харьцаа нь үнэт цаасны зах зээлд тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагын байвал зохих зхистой харьцааг хангаж байна.

Үнэт цаасны компаниудын 2015 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн нийт пассивын бүтэц дараах байдалтай байна. Үүнд: Тайлант хугацааны эцэст нийт пассивт эзлэх өр төлбөр 3261.56 тэрбум төгрөг буюу 87.69, эздийн өмч 457.91 тэрбум төгрөг буюу 12.31 хувийг

СЗХ | Зохицуулалтын салбарын нэгдсэн тойм

тус тус эзэлж байна. Нэгтгэлд хамрагдсан үнэт цаасны компаниудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 89.4 тэрбум төгрөг буюу нийт пассивын 2.40 хувийг эзэлж байна.

Жич: Тайлант хугацаанд нэр бүхий 19 үнэт цаасны компани үйл ажиллагаа явуулаагүй, арилжаанд оролцоогүй болно.

Шигтгээ-5:

Одоогийн байдлаар үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогч нь үнэт цаас гаргагч, мэргэжлийн зуучлагч, хөрөнгө оруулагч, зах зээлийн дэд бүтэц болох үнэт цаасны арилжаа, хадгаламж, төлбөр тооцооны байгууллагаас бүрдэж байна. Цаашид гаднын хөрөнгө оруулалтыг татах, эрсдлээс сэргийлэх зорилгоор тусгайлсан бүртгэлийн болон бие даасан төлбөр, тооцооны байгууллагын үйл ажиллагааг эхлүүлэхээр ажиллаж байна.

Хариуцлагын тогтолцоо, хүний нөөцийн чадавхи, санхүүгийн тайлагнал, эрсдэлд суурилсан зохистой харьцааны шалгуурыг хангасан үнэт цаасны компаниуд зах зээлд үйл ажиллагаа явуулснаар чанартай зуучлалыг бий болгож, гадаад дотоодын хөрөнгө оруулагчдын зах зээлд итгэх итгэл нэмэгдэнэ.

Дээрх ажлын хүрээнд Хорооны зүгээс тусгай зөвшөөрөл бүхий үнэт цаасны компаниудад хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг зохист түвшинд хүргэх ажлыг зохион байгуулж байна.

Үнэт цаасны зах зээлд оролцогчдод хууль зүйн зөвлөгөө өгөх, хөрөнгийн үнэлгээ хийх, аудитын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй зохицуулалттай этгээд:

Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй үнэт цаасны зах зээлд оролцогчдод аудитын, үнэлгээний болон хуулийн үйлчилгээ үзүүлэх нийт 67 компани байна. Үүнд:

Хүснэгт 7. Үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэгч байгууллага

№	Үйл ажиллагааны чиглэл	Байгууллагын тоо
1	Үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх аудитын компани	33
2	Үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх үнэлгээний компани	19
3	Үнэт цаасны зах зээлд оролцогчдод үйлчилгээ үзүүлэх хуулийн компани	15
Нийт		67

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

3.5. Өөрийгөө зохицуулах байгууллага:

Хорооны 2015 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 273 дугаар тогтоолоор “МҮЦАЭХ” ТББ анхны өөрийгөө зохицуулах байгууллагаар бүртгэгдлээ.

Ингэснээр үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрх авсан мэргэжилтнүүдээс бүрдсэн гишүүнчлэлтэй, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах, мэргэжлийн үйл ажиллагаа болон ёс зүйн нийтлэг журмыг тогтоох, гишүүдийнхээ чадавхийг дээшлүүлэх зорилго бүхий байгууллага албан ёсоор үйл ажиллагаагаа эхэлж, төр болон хувийн хэвшлийн түншлэл сайжрах, зах зээлийн хяналт нэмэгдэх давуу талтай.

3.6. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж:

“Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК нь 2013 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр анхны арилжаагаа эхлүүлснээс хойш 2015 оны эхний хагас жилийн байдлаар өссөн дүнгээр нийт 1.2 их наяд төгрөгийн арилжааг хийгээд байна.

СЗХ | Зохицуулалтын салбарын нэгдсэн тойм

Тус бирж нь 2015 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар нийт 94 удаагийн арилжаа зохион байгуулж 4755 тонн ноолуур, 53 тонн тэмээний ноос, 4236 тонн хонины ноос, 914 тонн ямааны завод ноос, 469 тонн завод ноос /хонь тэмээний/, 554 тонн хүнсний буудайтус тус арилжиж нийт 298.1 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

Хүснэгт 8. ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн зах зээлийн арилжаа

Хөдөө аж ахуйн биржийн 2015 оны эхний хагас жилийн түүхий эдийн арилжааны үнийн дүн (сая.төгрөг)

Төрөл	Хэмжээ (тн)	Үнийн дүн
Ноолуур	4,755	271,309
Тэмээний ноос	53	354
Хонины ноос	4,236	6,706
Ямааны завод ноос	914	18,871
Завод ноос / тэмээ, хонины	469	588
Хүнсний буудай	554	304
Дүн	10,981	291,132

Эх сурвалж: ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн бирж

График 3. Хөдөө аж ахуйн бирж дээрх түүхий эдийн арилжааны дүн



Эх сурвалж: ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн бирж

Уг бирж дээр шууд арилжих /spot/ гэрээгээр бараа, түүхий эдийн арилжааг явуулдаг ба 2015-2016 онуудад бараа, түүхий эдэд суурилсан нэг загварын гэрээ /фьючерс/-ний арилжааг эхлүүлэхээр бэлтгэл ажлуудыг хангаж байна.

Шигтгээ 6:

Өмнөх онуудын биржийн арилжаанаас харахад манай орны цаг уурын байдал, бараа, түүхий эдийн бэлтгэлийн онцлогоос хамаарч дийлэнх арилжаа 4 дүгээр сараас 6 дугаар сарын сүүл хүртэл явагджээ.

Харин 2015 оны эхний хагас жилийн арилжааны дүнгээс харахад 2014 оны нийт арилжааны 53.8 хувьтай тэнцэх хэмжээнд байгаа нь өнгөрсөн өвөл нийт нутгаар дулаан байсантай холбоотой голлох бараа болох ноолуурын ургалт муу,

СЗХ | Зохицуулалтын салбарын нэгдсэн тойм

ширхэг богино байсан нь үнэлгээнд сөргөөр нөлөөлсөн байна. Мөн малчид үнэ хани өсөх хүлээлттэй байгаагаас ноолуураа шууд борлуулах сонирхол бага байна гэсэн дүгнэлт өгөхөөр байна.

2015 оны хавраас эхэлж биржээр хүнсний буудай арилжаалж эхэлсэн ба энэ оны намрын ургац хураалтын үеэр хүнсний буудайн арилжаа идэвхижих эерэг хүлээлт байна. Цаашид биржээр арилжаалагдах бараа, түүхий эдийн төрлийг олируулах, гэрээний арилжааг хөгжүүлэх шаардлага үүсээд байна.

IV БҮЛЭГ: ДААТГАЛЫН САЛБАРЫН ТОЙМ

Олон улсад даатгалын салбар:⁴ Даатгалын компаниуд бага хүүгийн түвшин, эдийн засгийн сааралтын эсрэг хураамжийн орлогоо бууруулахгүй байхад анхаарал хандуулж байгаагаас 2007 оноос хойш буурч байсан ердийн даатгалын хураамжийн орлого 2013 оноос өсч эхэлсэн.

Харин урт хугацаат даатгалын хураамжийн орлого 2007 оноос хойш бууралттай байгаа нь санхүүгийн зах зээлийн хэлбэлзэл болон хүүгийн түвшин амьдралын даатгалд хүчтэй нөлөөлсөөр байгаад оршино.

4.1. Даатгалын салбарын статистик үзүүлэлтүүд:

2015 оны 2 дугаар улиралд 1 урт хугацаат даатгалын компани 5 хэлбэрийн 13 даатгалын бүтээгдэхүүн, 15 ердийн даатгалын компани 16 хэлбэрийн давхардсан тоогоор 511 даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд санал болгож ажилласан байна. Нийт 21 хэлбэрийн 524 даатгалын бүтээгдэхүүнийг 3210 даатгалын төлөөлөгч, 33 даатгалын зуучлагч, түүний 171 салбараар олон нийтэд даатгалын үйлчилгээг хүргэж, даатгалын гэрээ хийх хэлбэрээр ажиллав. Тайлант хугацаанд 21 даатгалын хохирол үнэлэгч 52 салбараар даатгалын гэрээний дагуу олгох даатгуулагчид учирсан хохирлыг үнэлж бодит хохирлын хэмжээг тогтоосон байна.

Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 25 компани, 8 банк үйл ажиллагаа явуулж байна. Банкууд даатгалын зуучлал хийх болсноор даатгалын зуучлалын дэд бүтэц сүүлийн жилүүдэд хурдацтай тэлсэн.

2015 оны 2 дугаар улирлын байдлаар даатгалын нийт хураамжийн орлогын 92 хувийг даатгалын компани болон даатгалын төлөөлөгчид, 8 хувийг даатгалын зуучлагчид төвлөрүүлсэн байна.

График 4. Даатгалын хураамжийн орлого төвлөрүүлэлт



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Улирлын өссөн дүнгээр нийт 617935 иргэн, аж ахуйн нэгж даатгуулсан бөгөөд өмнөх оны мөн үеэс 3.3 хувиар буурчээ. Үүнд ердийн даатгалын даатгуулагчийн тоо буурч, харин урт хугацааны даатгалд даатгуулагчид өссөн байна.

⁴ IAIS Global insurance market report (GIMAR) 2014

№	Тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигч	2009	2010	2011	2012	2013	2014.II	2015.II
1	Ердийн даатгалын компани	17	16	16	17	16	16	15
2	Урт хугацааны даатгалын компани	1	1	1	1	1	1	1
3	Давхар даатгалын компани	0	0	0	0	0	0	1
4	Даатгалын төлөөлөгч	1676	2061	2057	2357	3187	3171	3210
5	Даатгалын зуучлагч	5	9	8	17	20	24	33
6	Даатгалын хохирол үнэлэгч	2	6	9	9	14	17	21
7	Актуарч	10	12	13	18	15	15	15
БҮГД		1711	2105	2104	2419	3253	3244	3296


Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2015 оны 2 дугаар улирлын даатгалын салбарын нийт активын 82 хувийг ердийн, 3.9 хувийг урт хугацааны, 14.1 хувийг хөдөө аж ахуйн давхар даатгалын компани тус тус бүрдүүлжээ.

Хүснэгт 10. Даатгалын салбарын үйл ажиллагааны үзүүлэлтүүд /тэрбум.төгрөг/

Үзүүлэлтүүд	2011.II	2012.II	2013.II	2014.II	2015.II
Нийт хөрөнгийн хэмжээ	72.2	94	113.2	136.7	170.6
Давхар даатгалын хураамж	5.4	11.3	11	17.2	26
Даатгалын нөөц сан	33.9	46	53.3	64.7	74.2
Даатгалын хохирлын харьцаа/хувиар/	29.1	30	42.3	45	48.9
Хураамжийн орлого	24.3	41.9	42.4	57.1	65.9
Нөхөн төлбөр	4.3	6.5	11.8	15.6	17,6

График 5. Даатгалын, давхар даатгалын компаниудын нийт хөрөнгө



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2015 оны 2 дугаар улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж буй даатгалын болон давхар даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 170.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 33.9 тэрбум төгрөгөөр буюу 24.8 хувиар өссөн байна. Нөхөн төлбөрийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.4 тэрбум төгрөгөөр буюу 15.4 хувиар өслөө.

	Даатгуулагчийн тоо		Нөхөн төлбөр авсан	
	Хувь хүн	ААН	Хувь хүн	ААН
2011.II	529,970	13,074	6,933	5341
2012.II	547,303	36,500	5,874	6,699
2013.II	319,980	31,834	14,458	7550
2014.II	580,578	58,555	16,948	8,884
2015.II	535,315	82620	18,247	8,143

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2015 оны 2 дугаар улирлын байдлаар даатгалын хураамжийн орлогын дүнг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 12. Ердийн даатгалын хураамжийн орлогын хэмжээ

Хураамжийн орлогын үзүүлэлтүүд %		2011.II	2012.II	2013.II	2014.II	2015.II
Ердийн даатгал	Нийт хураамжийн орлого	100	100	100	100	100
	(Давхар даатгалын хураамж)	22.37	27.09	26.25	30.49	39.92
	(Буцаасан даатгалын хураамж)	0.28	0.57	0.42	1.82	1.27
	Цэвэр хураамжийн орлого	77.35	72.34	73.34	67.50	58.82

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Манайд үндэсний давхар даатгалын компани үйл ажиллагаа явуулдаггүйгээс шалтгаалан даатгалын компаниудын хураамжийн нийт орлогын 39.9 хувь нь гадаадын давхар даатгалын компаниудад шилжигдэж, валютын гадагшлах урсгалыг нэмэгдүүлж, ханшийн хэлбэлзэл үйлчилгээний зардлыг нэмэгдүүлэх эрсдэл өндөр хэвээр байна.

Хүснэгт 13. Урт хугацаат даатгалын хураамжийн орлого

Урт хугацаат даатгал	Үзүүлэлтүүд /хувиар/	2011-II	2012-II	2013-II	2014-II	2015-II
	Хураамжийн орлого	100.00	100.00	100.00	100.00	100.00
	Давхар даатгалын хураамж	37.25	28.52	2.49	6.13	0.63
	Цэвэр хураамжийн орлого	62.75	71.48	97.51	93.87	99.37

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

4.2. Даатгалын салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээ:

2015 оны 2 дугаар улирлын байдлаар хураамжийн орлого 65.98 тэрбум төгрөг ба түүний 77.1 хувийг 4 төрлийн бүтээгдэхүүний орлого бүрдүүлжээ. Орлогын бүтцийг задалвал: Нийт орлогын 22.5 хувийг хөрөнгийн, 19.5 хувийг жолоочийн хариуцлагын албан журмын, 13 хувийг авто тээврийн хэрэгслийн, 22 хувийг агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгалын орлого тус тус эзэлж байна.

Хөрөнгийн болон жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамжийн орлогын хэмжээ бусад бүтээгдэхүүний орлогоос өндөр байгаад дараах хүчин зүйлс нөлөөлжээ.

Шигтгээ-7:

Төрөөс хэрэгжүүлж буй иргэдийг орон сууцжуулах хөтөлбөрийн хүрээнд орон сууцны хөнгөлөлттэй зээлийг олгоход арилжааны банкууд заавал хөрөнгийн болон зээлдэгчийн амь нас гэнэтийн ослын даатгал хийлгэх шаардлагыг зээл олгох журамд тусгасан

Жолоочийн даатгалын тухай хуулиар жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд замын хөдөлгөөнд оролцож байгааг жолоочийг заавал даатгуулах, зам, тээврийн осол гаргаж бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хохирогчийн эрхийг хамгаалах зорилгоор албан журмын даатгалыг зохицуулж өгсөн зэрэг нь даатгалын хураамжийн орлогын хэмжээг нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлжээ

Даатгалын хураамжийн орлогын төвлөрөл, бүтээгдэхүүний нэр, төрлөөс үзэхэд, иргэд, аж ахуйн нэгж дээр дурьдсан албан журмын даатгалд даатгуулж харин сайн дурын даатгалд төдийлөн даатгуулах сонирхолгүй байгаа нь даатгалын үйлчилгээний ач холбогдлын талаарх олон нийтийн мэдлэг, мэдээлэл бага байгаатай шууд холбоотой.


4.3. Даатгалын салбарын хөгжлийн үзүүлэлтүүд:

Хүснэгт 14. Даатгалын гүнзгийрэлт

	ДНБ /тэрбу м.төг/	Цэвэр хураамжийн орлого /тэрбум.төг/	Даатгалын нэвтрэлт	Урт хугацааны даатгалын цэвэр хураамжийн орлого /тэрбум.төг/	Урт хугацааны даатгалын нэвтрэлт	Ердийн даатгалын цэвэр хураамжийн орлого /тэрбум.төг/	Ердийн даатгалын нэвтрэлт
2011.П	3582.73	18.75	0.52%	0.10	0.003%	18.65	0.52%
2012.П	4595.19	30.37	0.66%	0.33	0.005%	30.04	0.65%
2013.П	5075.52	31.21	0.61%	0.45	0.005%	30.75	0.61%
2014.П	5823.66	38.74	0.67%	0.70	0.007%	38.04	0.65%
2015.П	6166.81	39.13	0.63%	0.79	0.011%	38.34	0.62%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Жич: Даатгалын гүнзгийрэлтийг тооцохдоо давхар даатгалын хураамж эдийн засгийн эргэлтэд ордоггүйн улмаас цэвэр хураамжийн орлогыг дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулсан болно.



2015 оны 2 дугаар улирлын байдлаар нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх цэвэр хураамжийн орлого 0.63 хувь, ердийн даатгалын цэвэр хураамжийн орлого 0.62 хувийг тус тус эзэлж байна.

Даатгалын нягтрал

Хүснэгт 15-оос үзэхэд, даатгалын салбарын нягтралын үзүүлэлт сүүлийн таван жилийн байдлаар өссөн дүнтэй харагдаж байгаа боловч өсөлтийн хувь нь буурах хандлагатай байна.

Хүснэгт 15. Даатгалын нягтрал

Д/Д	Нягтрал (Хураамжийн орлого/хүн ам)	Өсөлт %	Хураамжийн орлого (төгрөг)	Хүн амын тоо	Хураамжийн орлогын өсөлт %	Хүн амын тооны өсөлт %
2010	8 627.41		23 820 000 000.00	2 760 968	-	-
2011	13 004.42	51	36 564 094 895.42	2 811 666	54	2
2012	20 045.70	54	57 485 930 433.12	2 867 744	57	2
2013	22 900.18	14	67 103 867 873.22	2 930 277	17	2
2014	24 681.16	8	73 943 509 753.95	2 995 949	10	2

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

График 7. Даатгалын нягтрал



Зохистой харьцааны үзүүлэлтүүд

Даатгалын компаниудын тооцож байх гол үзүүлэлт болох зардлын харьцаа, хохирол нөхөлтийн харьцаа болон тэдгээрийн хосолсон харьцааг тооцож үзэхэд хохирол нөхөлтийн харьцаа салбарын хэмжээнд 50 хувиас бага буюу хэвийн түвшинд байгаа боловч зардлын харьцаа маш өндөр байна. Энэ нь даатгалын компаниудын зардал өндөр байгааг илтгэж байна.

2015 оны 2 дугаар улирлын байдлаар даатгалын компаниудын зохистой харьцааны үзүүлэлтүүдийг хүснэгтээр үзүүлбэл дараах байдалтай байна.

Хүснэгт 16. Даатгалын салбарын зохистой харьцаа

Зохистой харьцаанууд	Боломжит түвшин	Нийт дүнгээр	Хамгийн өндөр үзүүлэлт	Хамгийн бага үзүүлэлт	ТАЙЛБАР
Нийт хөрөнгийн өгөөж (%) = (Даатгалын цэвэр хураамж / Нийт хөрөнгө)	-	26.700	45.46	2.05	
Зардлын харьцаа (%) = (ҮАЗ / ОТхураамж)	25 ≤ 60	63.01	126.62	47.96	Компаниудын хувьд үйл ажиллагааны зардал өндөртэйг харуулж байна.
Хосолсон харьцаа (%) = (Нөхөн төлбөр + ҮАзардал/ОТхураамж)	85 ≤ 105	111.88	172.61	68.39	Энэ харьцаа нь 100 хувиас их нөхцөлд компанийн хөрөнгө оруулалтын ашигтай ажиллахыг шаарддаг
Хохирлын харьцаа (%) = (Төлсөн нэхэмжлэл / ОТхураамж)	≤ 100	48.86	80.77	6.08	

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

V БҮЛЭГ: БИЧИЛ САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОЙМ

5.1. Бичил санхүүгийн салбарын өнөөгийн байдал:

Банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн чанарыг өмнөх онуудтай харьцуулахад нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь сүүлийн 5 жилийн дунджаас 2.2 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд макро эдийн засгийн тогтворгүй байдал, эдийн засгийн өсөлт буурсантай холбоотойгоор иргэд, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, орлогын хэмжээнд шууд нөлөөлсөнөөр эргээд банк бус санхүүгийн байгууллагуудын чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэхэд хүргэж байна.

5.2. Банк бус санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид:

Хүснэгт 17. ББСБ-ын тоо

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо <i>/давхардсан тоогоор/</i>			
		2014-II	2015-II	Өөрчлөлт	
		тоо	тоо	тоо	хувь
	Нийт ББСБ-ын тоо	326	423	97	29.8
1	Зээл	274	361	87	31.8
2	Гадаад валютын арилжаа эрхэлдэг	118	131	13	11.0
	Үүнээс: зөвхөн гадаад валютын арилжааг дагнан эрхэлдэг	50	52	2	4.0
3	Факторингийн үйлчилгээ	16	17	1	6.3
4	Төлбөрийн баталгаа гаргах	11	13	2	18.2
5	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	6	6	-	-
6	Итгэлцлийн үйлчилгээ	23	25	2	8.7
7	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2	2	-	
8	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	25	26	1	4.0

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


2015 оны 2 дугаар улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагын тоо 423-т хүрч өмнөх оны мөн үеийнхээс 97 буюу 29.8 хувиар өссөн бөгөөд тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллаганы төрлөөр нь ангилан харуулвал зээлийн үйл ажиллагаа эрхлэх 31.8 хувь, гадаад валютын арилжаа эрхэлдэг 11 хувь, факторингийн үйлчилгээ 6.3 хувь, төлбөрийн баталгаа гаргах 18.2 хувь, итгэлцлийн үйлчилгээ эрхлэх 8.7 хувийг тус тус бүрдүүлж байна.

Улсын хэмжээнд 423 компани банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байгаагийн 88.9 хувь буюу 376 нь Улаанбаатар хотод, 11.1 хувь буюу 47 нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

5.3. Банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн үзүүлэлт

Активын үзүүлэлтүүд:

График 8. ББСБ-ын актив



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Банк бус санхүүгийн байгууллагуудын нийт активыг ДНБ-д харьцуулсан үзүүлэлт 2015 оны 2 дугаар улиралд 9 хувьтай гарсан бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 1.3 хувиар өссөн. ДНБ-д харьцуулсан нийт активын үзүүлэлт санхүүгийн зах зээлд банк бус санхүүгийн байгууллагуудын эзлэх багтаамж болон тэдгээрийн үйлчилгээний хүртээмжтэй байдлыг харуулдаг.

Шигтгээ-8:

Бичил санхүүгийн салбарт банк бус санхүүгийн байгууллагуудын тоо өсч байгаа нь арилжааны банкуудын дундаж хүүнээс өндөр хүүтэй зээл олгож байгаа нөхцөлд чанаргүй зээлийн хэмжээ өсөх эрсдлийг нэмэгдүүлж байна. Эрсдэл даах чадвартай, үйл ажиллагаа нь жигдэрсэн, мэргэжлийн боловсон хүчин сайтай санхүүгийн байгууллагууд ажиллах нь салбарын тогтвортой байдлыг хангахад чухал нөлөө үзүүлнэ. Санхүүгийн зах зээлд эзлэх банк бус санхүүгийн байгууллагуудын үйлчилгээг сайжруулж, зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэн эдийн засгийг дэмжихийн тулд Хорооноос эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлэх чиглэлээр тодорхой шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

График 9. Нийт активын өсөлт /тэрбум төгрөгөөр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Банк бус санхүүгийн байгууллагын нийт активын хэмжээ 2006-2014 онд 508 тэрбум төгрөгт хүрч нэмэгдсэн байна. 2015 оны 2 дугаар улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагуудын нийт активын хэмжээ 554.5 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 110.9 тэрбум төгрөг буюу 25 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан. Нийт

СЗХ | Зохицуулалтын салбарын нэгдсэн тойм

активын хэмжээ өсөхөд зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 92.0 тэрбум төгрөг буюу 34 хувиар, хувьцаат капитал өмнөх оны мөн үеэс 63.2 тэрбум төгрөг буюу 28.5 хувиар, хуримтлагдсан ашиг өмнөх оны мөн үеэс 25.2 тэрбум төгрөг буюу 53.3 хувиар тус тус өссөн зэрэг нь гол нөлөөг үзүүлсэн.

График 10. Нийт хөрөнгийн бүтэц



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Банк бус санхүүгийн байгууллагын нийт активын бүтцийн 96.6 хувийг эргэлтийн хөрөнгө, 3.4 хувийг эргэлтийн бус хөрөнгө тус тус эзэлж байгаа бөгөөд эргэлтийн хөрөнгийн задаргааг харуулвал дараах байдалтай байна.


Хүснэгт 18. ББСБ-ын эргэлтийн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөг/

Д/д	Эргэлтийн хөрөнгө	2014-И	2015-И	Өөрчлөлт	Хувь
1	Мөнгөн хөрөнгө	126.9	144.9	17.9	14.1
2	Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	10.8	11.1	0.27	2.5
3	Нийт зээл	270.4	362.3	91.9	34.0
	(Зээлийн эрсдлийн сан)	10.8	21.0	10.3	97.0
4	Нийт санхүүгийн түрээсийн тооцооны авлага	0.006	0.007	0.001	15.8
	(Санхүүгийн түрээсийн эрсдлийн сан)	0.0	0.0	0.0	0.0
5	Нийт факторингийн тооцооны авлага	0.08	0.09	0.008	10.4
	(Факторингийн авлагын эрсдлийн сан)	0.0015	0.0030	0.0029	2040
6	Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	1.3	1.7	0.43	33.0
7	Бусад хөрөнгө	28.3	36.4	8.09	28.6
	Нийт дүн	427.1	535.5	108.4	25.4

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зээлийн үзүүлэлт:

График 11. Нийт зээл, зээлийн чанар /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант үеийн зээлийн үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл, нийт зээлийн хэмжээ 92.0 тэрбум төгрөгөөр буюу 34.0 хувиар өссөн боловч /өмнөх оны энэ улирлын өсөлт 43.7 хувь байсан/ өсөлтийн хурдац нь саарах, зээлийн бүтцийн хувьд төгрөгийн зээл буурах, гадаад валютаар олгох зээлийн хэмжээ нэмэгдэх хандлагатай байна.

Нийт чанаргүй зээлийн хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.0 тэрбум төгрөг буюу 84.7 хувиар өссөн. Чанаргүй зээлийн хэмжээ, түүний дотор муу зээлийн хэмжээ 2 дахин нэмэгдсэнтэй холбогдон зээлийн эрсдлээс хамгаалах сан өмнөх оны мөн үеийнхээс 10.4 тэрбум төгрөгөөр буюу 97.0 хувиар өссөн байна.

5.4. Банк бус санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааны үзүүлэлт:

Бичил санхүүгийн салбарын үйл ажиллагааны үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 19. ББСБ-ын бүтэц

№	Үзүүлэлтүүд /байгууллагын бүтэц/	2014-II	2015-II	Өөрчлөлт
1	ББСБ-ын тоо	326	423	97
2	Хувьцаа эзэмшигчдийн тоо	768	849	81
3	Ажиллагсадын тоо	1632	1774	142
4	Салбар нэгжийн тоо	89	99	10
5	Харилцагчдын тоо	471,090	457,540	(13,550)

№	Үзүүлэлтүүд /байгууллагын үйл ажиллагаа, тэрбум төгрөг/	2014-II	2015-II	Өөрчлөлт /хувиар/
1	Нийт олгосон зээл	270,3	362,3	34
2	Нийт өөрийн хөрөнгө	279,4	368	31.7

СЗХ | Зохицуулалтын салбарын нэгдсэн тойм

3	Нийт хувьцаат капитал	221,8	285	28.5
4	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	24,3	32,5	33.5
5	Банк, банк бус санхүүгийн байгууллагаас татсан зээл:	113,7	123,6	8.7
	Богино хугацаат	65	65,8	1.2
	Урт хугацаат	48,7	57,8	18.8
8	Төслийн зээлийн санхүүжилт	12,5	14,2	13.8
9	Нийт орлого	63,5	77,1	21.4
10	Нийт зардал	47,5	56,2	18.1
11	Тайлант үеийн цэвэр ашиг	16	21	31.2

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Банк бус санхүүгийн байгууллагуудын бүтцийн үзүүлэлтийн хувьд өмнөх оны мөн үеэс өссөн дүр зураг харагдаж байгаа боловч харилцагчдын тоо 13550-аар багассан. Үйл ажиллагааны үзүүлэлтүүдийн хувьд 8-34 хувийн өсөлттэй гарав.

Шигтгээ-9:

Банк бус санхүүгийн байгууллагуудын тайлант үеийн цэвэр ашиг 21.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 31.2 хувиар өссөн бөгөөд хүүгийн орлого 55.4 тэрбум төгрөгт хүрч, 33.6 хувиар өссөн нь гол нөлөөг үзүүлжээ. Манай улсын эдийн засгийн өсөлт буурч, макро эдийн засгийн нөхцөл байдал хүндэрч байгаа үед үүнийг дагаад арилжааны банк болон ББСБ-дын чанаргүй зээлийн хэмжээ өссөнөөр тодорхой хэмжээний эрсдлийг санхүүгийн системд бий болгоод байна. Эдийн засгийн өсөлт буурч байгаатай холбоотойгоор аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагааны ашиг орлого буурч, эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг зээл хэлбэрээр авахад арилжааны банкуудын шаардлага өсч, төлөгдөх боломжгүй, чанаргүй зээл болох магадлалтай зээлүүдийг олгохгүй байгаа нь банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн хэмжээ өсөхөд нөлөөлсөн.

5.5. Хадгаламж зээлийн хоршооны өнөөгийн байдал

Хадгаламж зээлийн хоршоодын ДНБ-д харьцуулсан нийт активын үзүүлэлт тайлант хугацаанд 1.38 хувьтай гарсан бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.06 хувиар өссөн. Дээрх өсөлтөд Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй ХЗХ-ын гишүүдийн тоо 6582-оор өсч, нийт актив 7.11 тэрбум төгрөг буюу 10.8 хувиар, орон нутгийн ХЗХ-ын гишүүдийн тоо 1207-оор өсч, нийт актив 1.6 тэрбум төгрөг буюу 15.0 хувиар тус тус өссөн нь гол нөлөөг үзүүлсэн. Тайлант хугацаанд цэвэр зээлийн үлдэгдлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.3 тэрбум төгрөг буюу 13.8 хувиар өссөн бол чанаргүй зээлийн үлдэгдэл 0.42 тэрбум төгрөг буюу 23.4 хувиар өссөн байна. Хадгаламж зээлийн хоршоодын нийт олгосон зээлийн хэмжээ ДНБ-тэй харьцуулахад 1.14 хувь, нийт хадгаламжийн хэмжээ ДНБ-тэй харьцуулахад 0.9 хувьтай байна. Хадгаламж зээлийн хоршоодын ашигт ажиллагааны хувьд 2015 оны 2 дугаар улирлын байдлаар 123 ХЗХ 1.59 тэрбум төгрөгийн ашигтай, 39 ХЗХ ашиг, алдагдалгүй, 80 ХЗХ 0.22 тэрбум төгрөгийн алдагдалтай тус тус ажиллаж салбарын хэмжээнд нийт 1.37 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, салбарын активын өгөөж 1.6 хувьд хүрсэн бөгөөд салбарын ашгийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 0.52 тэрбум төгрөгөөр буюу 27.5 хувиар буурсан үзүүлэлттэй гарлаа. Тайлант хугацаанд хадгаламж зээлийн хоршоодын нийт зардлын хэмжээ 23.8 хувиар өссөн нь ашиг буурахад нөлөөлсөн байна.

5.6. Хадгаламж зээлийн хоршоод, тэдгээрийн үндсэн үзүүлэлтүүд:

Хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагаа эрхлэгчид, гишүүдийн тоо, санхүүгийн үйл ажиллагааны үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулсан байдлаар хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 20. ХЗХ-ны үндсэн үзүүлэлтүүд /мянган төгрөг/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2014 оны II	2015 оны II	Өөрчлөлт	
				дүн	хувь
1	ХЗХ-дын тоо	139	242	103	74.1%
2	Гишүүдийн тоо	27,517	35,306	7,789	28.3%
3	Нийт актив	76,841,469.7	85,609,086.6	8,762,916.9	11.4%
4	Нийт зээлийн үлдэгдэл	61,539,116.8	70,773,093.2	9,233,976.4	15.0%
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	1,815,813.0	2,240,627.3	424,814.3	23.4%
6	Нийт татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл	52,569,553.1	55,818,143.2	3,248,590.1	6.2%
7	Нийт хувь хөрөнгийн үлдэгдэл	10,104,833.0	10,420,677.3	311,144.3	3.1%
8	Нийт хоршоологчдын өмчийн үлдэгдэл	7,071,919.4	8,692,295.7	1,620,376.3	22.9%
9	Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн дүн	1,300,108.0	5,804,766.7	4,504,658.7	346.5%
10	Нийт орлого	9,164,137.8	10,377,765.2	1,213,627.4	13.2%
11	Нийт зардал	7,280,573.7	9,011,865.9	1,731,292.2	23.8%
12	Тухайн үеийн ашиг, алдагдал	1,883,564.1	1,365,899.3	-517,664.8	-27.5%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Өмнөх оны мөн үеэс нийт ХЗХ-дын гишүүдийн тоо 21 хувиар, нийт актив 13 хувиар тус тус өссөн байна. Мөн нийт зээл болон татан төвлөрүүлсэн хадгаламжийн банкны салбарт эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.1 хувиар өссөн байна. Нийт актив 9.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд гишүүдийн хадгаламж 4.5 тэрбум төгрөгөөр, бусдаас авсан зээлийн эх үүсвэр 4.1 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.


"Бичил бизнесийг дэмжих ядуурлыг бууруулах "Нийслэлийн хөтөлбөр"-ийн хүрээнд бичил бизнесийн зээлд иргэдийг хамруулах зорилгоор Нийслэлийн хороодод хадгаламж, зээлийн хоршоог байгуулах санаачлага үүсч 4.63 тэрбум төгрөгийн санхүүжилтийг ХЗХ-дод олгосон нь банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн эх үүсвэрийг өмнөх оны мөн үеийнхээс 3.5 дахин нэмэгдүүлэхэд нөлөөлсөн байна.

Тайлант хугацаанд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 242 ХЗХ-д байгаагийн 64.9 хувь буюу 157 ХЗХ нь Улаанбаатар хотод, 35.1 хувь буюу 85 ХЗХ нь орон нутагт үйл ажиллагаагаа явуулж байна.

Хадгаламж зээлийн хоршоодын зээлийн үзүүлэлтүүд:

Хадгаламж зээлийн хоршоодын нийт зээл, зээлийн чанарыг графикаар үзүүлбэл дараах байдалтай байна.

График 12. Нийт зээлийн хэмжээ




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант хугацаанд цэвэр зээлийн үлдэгдлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.3 тэрбум төгрөг буюу 13.8 хувиар өссөн бол чанаргүй зээлийн үлдэгдэл 0.42 тэрбум төгрөг буюу 23.4 хувиар өссөн бөгөөд ХЗХ-дын нийт зээлийн багц 70.77 тэрбум төгрөг байгаа нь нийт активын 82.7 хувьтай, цэвэр зээл 68.95 тэрбум төгрөг байгаа нь нийт активын 80.5 хувьтай тус тус тэнцэж байна.

Хадгаламж зээлийн хоршоодын хадгаламжийн үзүүлэлтүүд:

График 13. Хадгаламж, зээлийн хоршоодын хадгаламжийн өөрчлөлт




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант хугацаанд татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 55.82 тэрбум төгрөг буюу нийт эх үүсвэрийн 65.2 хувийг эзэлж байгаа бөгөөд үүний 54.49 тэрбум төгрөг буюу 97.6 хувь нь 12094 гишүүний хугацаатай хадгаламж байгаа бол 1.33 тэрбум төгрөг буюу 2.4 хувь нь 3736 гишүүний хугацаагүй хадгаламж байна.

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдлийг ангилахад 0.5 тэрбум төгрөгөөс дээш хадгаламжийн үлдэгдэлтэй 12 ХЗХ-ны хадгаламжийн үлдэгдэл 47.32 тэрбум төгрөг байгаа нь нийт ХЗХ-дын хадгаламжийн үлдэгдлийн 84.8 хувийг эзэлж байгаа бол хадгаламж татан төвлөрүүлээгүй 64 ХЗХ байгаа нь нийт ХЗХ-дын 26.4 хувийг эзэлж байна.

График 14. Хадгаламж, зээлийн хоршоодын ашигт ажиллагаа



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант улиралд ХЗХ-дын нийт орлогын хэмжээ 10.38 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.21 тэрбум төгрөг буюу 13.2 хувиар өссөн бол нийт зардлын хэмжээ 9.01 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.73 тэрбум төгрөг буюу 23.8 хувиар өссөн ба салбарын хэмжээнд нийт 1.37 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.52 тэрбум төгрөг буюу 27.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

5.7 Зээлийн батлан даалтын сан

Монгол Улсын Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль 2012 оны 2 дугаар сарын 10-ны өдөр батлагдсан. Уг хуулийн хүрээнд 10 дугаар сарын 29-ний өдөр Зээлийн батлан даалтын санг үүсгэн байгуулахаар Засгийн газар, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын төлөөлөл санамж бичиг байгуулан 2012 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр сангийн дүрэм батлагдсанаар ”Зээлийн батлан даалтын сан“ үүсгэн байгуулагдсан.

Сангийн үүсгэн байгуулагч нь Монгол Улсын Засгийн газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо юм. Зээлийн батлан даалтын сан нь барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд батлан даалт гаргах ашгийн төлөө бус байгууллага юм. Шуурхай, ил тод, найдвартай үйлчилгээгээр жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжих, улмаар Монгол улсын эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулах эрхэм зорилготой ажиллаж байна. Сангийн зорилго нь жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, иргэдийн орлогын тогтвортой эх үүсвэрийг ханган явуулахад чиглэгдэж байна.

Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагаа:

2015 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар 364 аж ахуй нэгж байгууллага, иргэдийн 59.6 тэрбумтөгрөгийн зээлэнд 24.4 тэрбум төгрөгийн батлан даалтыг гаргах шийдвэр гаргасан байна. Сангаас гаргасан батлан даалтын дээд хэмжээ 250 сая төгрөг, доод хэмжээ 600 мянган төгрөг байна.

VI БҮЛЭГ: ЗОХИЦУУЛАЛТЫН САЛБАРУУДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТӨД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

6.1. Үнэт цаасны зах зээл:

Хөгжингүй орнуудын туршлагаас харахад зах зээлийн үнэлгээний дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 100-аас дээш хувийг эзэлдэг ба энэ нь үнэт цаасны зах зээлд эргэлдэж буй капиталын хэмжээ нь нийт эдийн засгийн гарцын хэмжээнээс өндөр болохыг илтгэж, урт хугацааны эдийн засгийн өсөлтийг голлон тодорхойлогч болдог.

Үнэт цаасны зах зээл нь урт хугацаандаа эдийн засгийн өсөлтөд дараах 3 үндсэн сувгаар дамжин нөлөөлнө.

- Үнэт цаасны зуучлалаар дамжуулан сул чөлөөтэй хуримтлалыг үр ашигтай хөрөнгө оруулалтын төслийг санхүүжүүлнэ;
- Хөрөнгө оруулагчийн хувьд үр ашигтай төслийг санхүүжүүлж ашиг олох ба үнэт цаас гаргагчийн хувьд өртөг багатай хөрөнгийн эх үүсвэрийг татахад гарч буй үйлдлийн болон мэдээллийн зардлыг бууруулдаг;
- Хөрөнгө оруулагчдад эрсдлээ оновчтой удирдах замаар хөрөнгөө үр ашигтай хуваарилах боломжийг олгодог.

Үнэт цаасны зах зээлийн хөгжил болон эдийн засгийн өсөлт дараах 3 хэлбэрээр харилцан хамааралтай эсэх таамаглалыг шалгаж тогтооно:

- Үнэт цаасны зах зээлийн хөгжил нь эдийн засгийн өсөлтийн учир шалтгаан;
- Эдийн засгийн өсөлт нь үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжигч;
- Үнэт цаасны зах зээлийн хөгжил ба эдийн засгийн өсөлт нь харилцан нэг нэгнийхээ учир шалтгаан.

6.2. Даатгалын салбар:

Даатгалын салбарын зуучлалын хөгжил нь эдийн засгийн өсөлтөд дор үзүүлсэн 4 үндсэн сувгаар нөлөөлдөг:

- Даатгалын салбар нь бизнесийн орчин дахь тодорхойгүй байдлыг арилгаж, хөрөнгө оруулалт, инноваци, санаачлагыг дэмжсэнээр эдийн засгийн өсөлтөд нөлөөлнө;
- Урт хугацааны арилжааны даатгал нь улсын нийгмийн даатгалын салбарын нэмэлт тогтолцоо болж хөгжсөнөөр урт хугацаанд эдийн засгийн өсөлтийг дэмжинэ;
- Арилжааны даатгал нь өөрийн нөөц хөрөнгөөр үнэт цаасны зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулагчийн үүднээс оролцож, зах зээлийг идэвхжүүлснээр санхүүгийн зах зээлийн хөгжилд нөлөөлнө;
- Даатгалын салбар нь бизнесийн салбарт эрсдлийн удирдлагын оновчтой тогтолцоог бүрдүүлснээр системийн эрсдэлээс урьдчилан сэргийлж, эдийн засгийн өсөлтөд дам нөлөөлдөг.

6.3. Бичил санхүүгийн салбар:

Бичил санхүүгийн салбарын эдийн засагт нөлөөлөх хүчин зүйлсийг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

- Санхүүгийн тогтвортой бичил санхүүгийн байгууллагууд нь зах зээлийг тэлж өргөжүүлснээр санхүүгийн хөгжлийг дэмждэг;
- Бичил санхүү нь хөгжсөн болон хөгжиж буй эдийн засагтай орнуудын аль алинд нь санхүүгийн зах зээлийн хөгжлийн хугацааг хурдасгадаг;
- Бичил санхүү нь эдийн засагт тулгардаг тодорхой хязгаарлалтыг бууруулснаар дотоодын санхүүгийн шинэчлэлд дэмжлэг болдог;
- Бичил санхүү нь өрхийн санхүүгийн зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлдэг.

VII БҮЛЭГ: ЗОХИЦУУЛАЛТЫН САЛБАРТ ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ

7.1. Зохицуулалттай салбарыг хөгжүүлэх чиглэлээр:

Үнэт цаасны зах зээл:

2014 онд Хороо нь Компанийн тухай хууль, Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль, Эрүүгийн хууль, Хохирлыг эргэн төлөх нөхцөлөөр барагдуулах тухай, Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай зэрэг 5 хуулиудыг боловсруулах, өөрчлөлт, нэмэлт өөрчлөлт оруулах, санал дүгнэлт өгөх ажлын хэсэгт орж ажиллан батлуулсан бөгөөд 15 хуульд судалгаа хийж санал өгчээ.

Мөн салбарын хэмжээнд мөрдөгддөг хууль тогтоомжуудад нийцүүлэн 20 журам шинээр, 3 журам шинэчлэн, 8 журамд нэмэлт өөрчлөлт, 9 журамд нэмэлт, 5 журамд өөрчлөлт оруулан баталж мөрдүүлснээс гадна 9 журам, журмын заалтуудыг хүчингүй болгосон байна. Эдгээр журмуудыг мөрдүүлснээр бичил санхүү, даатгал, хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлж, шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх, санхүүгийн зах зээлд оролцогчдод тавигдах шаардлагыг өндөржүүлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, зах зээлийн эрсдлийг бууруулах, үндэсний болон гадаадын хөрөнгө оруулагчдын зах зээлд оролцох сонирхлыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэв.

Улсын Их хурлаас 2015 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 52 дугаар тогтоолоор Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг баталсан бөгөөд уг үндсэн чиглэлд хөрөнгийн зах зээлийг хөгжлийг дэмжих, өсөлтийн нэмэгдүүлэхэд хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг жигдрүүлж, эдийн засгийг дэмжих болон үндэсний давхар даатгалын корпораци байгуулах, нийгмийн даатгалын зарим төрлийг хувийн амьдралын даатгалд шилжүүлэх замаар урт хугацааны болон хувийн тэтгэврийн даатгалын зах зээлийг хөгжүүлэх зэрэг арга хэмжээнүүд тусгагдсан.

Мөн Улсын Их хурлаас 2013 оны 10 дугаар сарын 03-ны өдөр баталсан Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиар хамтын болон хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, сангийн үйл ажиллагааг эрхлэхтэй холбогдуулан хөрөнгө оруулалтын менежментийн компанид тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зэрэг харилцааг зохицуулж өгсөн.

Хэдийгээр үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын хуулиуд батлагдсан хэдий ч хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг олон улсын стандартад нийцүүлэх шаардлагатай байгаа бөгөөд цаашид хөрөнгө оруулалтын банкууд болох кастодион банкны үйлчилгээг нэвтрүүлэх, төлбөр тооцооны систем, төлбөр тооцооны дундын нэгж /ССР/-ийг бий болгох, арилжаа, төлбөр тооцооны програмын уялдаа холбоог хангах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг идэвхжүүлэх шаардлагатай.

Хорооноос үнэт цаасны зах зээлийг хөгжүүлж, эдийн засгийг дэмжих зорилгоор урт хугацааны “Монгол улсын санхүүгийн зах зээлийн 2020 он хүртэлх хугацааны шинэчлэл, хөгжлийн хөтөлбөр”-ийн төслийг боловсруулсан. Уг хөтөлбөрт санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд шаардлагатай байгаа тэргүүлэх үндсэн таван чиглэл тусгагдсан бөгөөд санхүүгийн зах зээл дэх эрэлтийг нэмэгдүүлэх чиглэлийн хүрээнд хамтын болон хувийн хөрөнгө оруулалтын хаалттай болон нээлттэй сангуудыг үүсгэн байгуулах, зохицуулалтын оновчтой тогтолцоог бий болгох, нийгмийн даатгалын тэтгэврийн санд түшиглэсэн урт хугацаат хөрөнгө оруулалтын санг бий болгох зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Бичил санхүүгийн салбар:

Олон улсын валютын сангийн судалгаар 2015 онд бичил санхүүгийн зах зээл олон улсын хэмжээнд 15-20 хувиар өсөх төлөвтэй байгаа бөгөөд бичил санхүүгийн зах зээлтэй орнуудын эдийн засгийн өсөлт 4.4-4.8 хувьд хүрнэ гэсэн тооцоо гарсан.

Азийн хөгжлийн банкнаас Монгол улсын эдийн засгийн өсөлт 2015 онд 3 хувь, Олон улсын валютын сан 4.4 хувийн өсөлттэй байна гэж тус тус таамагласан ба гадаадын шууд хөрөнгө оруулалт, эрдэс бүтээгдэхүүний экспортын хэмжээ буурсантай холбоотойгоор макро эдийн засгийн нөхцөл байдал ирэх жилүүдэд сайжрах төлөв ажиглагдахгүй байна.

2015 оны 2 дугаар улирлын байдлаар бичил санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа банк бус санхүүгийн байгууллагуудын тоо 97-оор нэмэгдэн 423-т хүрч, цэвэр ашгийн хэмжээ өмөх оны мөн үетэй харьцуулахад 31.2 хувиар өсч, 21 тэрбум төгрөгт хүрээд байна.

Банк бус санхүүгийн байгууллагуудын тоо өсч, цэвэр ашгийн хэмжээ нэмэгдсэн ч арилжааны банкуудын дундаж хүүнээс өндөр хүүтэй зээл олгож байгаа нөхцөлд чанаргүй зээлийн хэмжээ өсөх эрсдлийг нэмэгдүүлж байна. Тайлант хугацаанд нийт чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 13.0 тэрбум төгрөг буюу 84.7 хувиар өссөн бөгөөд цаашид хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн өсөлт хэвийн зээлийн өсөлтөөс 15.5-54.8 хувиар хурдацтай өсөх хандлагатай байна. Макро эдийн засаг тогтворгүй, өсөлт буурч байгаа нөхцөлд олноор ББСБ-д байгуулагдах нь чанаргүй зээлийн хэмжээг өсөх эрсдлийг нэмэгдүүлэх тул эрсдэл даах чадвартай, үйл ажиллагаа нь жигдэрсэн, мэргэжлийн боловсон хүчин сайтай санхүүгийн байгууллагууд ажиллах нь салбарын тогтвортой байдлыг хангахын зэрэгцээ санхүүгийн зах зээлд эзлэх бичил санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлдэг.

Нөгөөтэйгүүр бичил санхүүгийн салбарын эдийн засагт дэмжлэг үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлэхийн тулд бичил санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд банкны салбартай хамтарч ажиллах, олон улсын бичил санхүүгийн туршлагыг нэвтрүүлж, санхүүгийн үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх, санхүүгийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр ажиллах шаардлага тулгараад байна.

Хорооноос бичил санхүүгийн салбарыг олон улсын түвшинд нийцүүлэн хөгжүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүнд:

1. ХЗХ болон ББСБ-даас санхүүгийн тайлан мэдээ, мэдээллийг хүлээн авах, мэдээллийн цахим сан бүрдүүлэх, боловсруулалт хийх нэгдсэн сүлжээг чанаржуулах, ХЗХ, ББСБ-даас санхүүгийн тайланг бүрэн авч, нэгтгэлд бүрэн хамруулах, FINA программд шалгаж хүлээж авах ажлыг сайжруулах;
2. Монголбанкны Зээлийн мэдээллийн сангийн ажиллагаанд ХЗХ болон ББСБ-уудыг бүрэн хамруулах;
3. ХЗХ, ББСБ-дын хугацаа хэтэрсэн зээл болон чанаргүй зээл их хэмжээгээр нэмэгдэж байгаа байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах;
4. ХЗХ, ББСБ-уудын хууль, тогтоомжоор хүлээсэн үүргийн хэрэгжилтийг сайжруулах, зайны болон газар дээрх шалгалтын үр нөлөөг дээшлүүлж, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэх;
5. Хадгаламж зээлийн хоршоодын ашгийн хэмжээ буурч, гишүүдийн тоо нэмэгдэж байгаа үед ХЗХ-ын гишүүдийн хадгаламжийг даатгуулах чиглэлээр тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх;
6. Бичил санхүүгийн салбарын эдийн засагт үзүүлэх нөлөөг нэмэгдүүлэхийн тулд олон улсын туршлагыг нэвтрүүлэх.

7.2. Нэгдсэн бодлого, зохицуулалтын чиглэлээр:

Үнэт цаас, даатгал, бичил санхүүгийн салбарын 2015 оны 2 дугаар улирлын статистик үзүүлэлтүүд болон салбаруудын тулгамдсан асуудал, дүгнэлтүүдэд тулгуурлан дараах нэгдсэн дүгнэлтийг хийлээ. Үүнд:

- ❖ Санхүүгийн зах зээлийн 2020 он хүртэлх хугацааны хөгжил, шинэчлэлийн хөтөлбөрийг үйл ажиллагааны стратеги болон ажлын төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлэх;
- ❖ Хорооноос албан журмын даатгалыг төрөлжүүлэх чиглэлээр холбогдох хууль, тогтоомжид өөрчлөлт оруулах;
- ❖ Нийгмийн хамгаалал, халамжийн хөрөнгийг хувийн даатгалын байгууллагаар дамжуулан хуримтлалын, урт хугацааны даатгалын бүтээгдэхүүн хэлбэрээр зорилтот бүлэгт хүргэх;
- ❖ Бичил санхүүгийн салбарыг олон улсад тогтсон ажлын байр нэмэгдүүлж, ядуурлыг бууруулах зорилгоор өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд чиглэсэн зээлийн санхүүжилтийн тогтолцоо хэлбэрээр хөгжүүлэх;
- ❖ Хорооны зохицуулалтын дүрэм, журмуудыг хөгжлийн хөтөлбөрт заасан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх чиглэлд бодлогын арга хэрэгсэл утгаар нь шинэчлэх;
- ❖ Санхүүгийн зах зээлийн нэгдсэн хяналт, шалгалтыг Хорооноос хэрэгжүүлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулж, эрсдэлд суурилсан хяналтыг нэвтрүүлэх.

Үнэт цаас, даатгал, бичил санхүүгийн салбарын өнөөгийн нөхцөл, байдлаас харахад санхүүгийн нийт салбарын хөгжлийг нэгдсэн нэг бодлогын хүрээнд нэгтгэн зангидах, цаашилбал нэгдсэн хяналт, шалгалтыг Хорооноос дагнан хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна. Мөн төрөөс баримталж буй мөнгөний болон сангийн бодлогод Хорооны стратеги, хөтөлбөрийг нийцүүлэх, тэдгээрт тусгуулах нь чухал.

—oOo—

Хавсралт 1. Үнэт цаасны зах зээлийн хувьцаат компани болон мэргэжлийн оролцогчдын 2015 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэл

1. Хувьцаат компанийн санхүүгийн байдал

Нийт 177 хувьцаат компани /мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	123 571 844.10	104 375 593.90
1.1.2	Дансны авлага	323 646 862.30	330 629 392.80
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	25 411 032.20	7 593 692.20
1.1.4	Бусад авлага	44 080 528.90	45 845 911.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	14 065 362.50	23 203 635.90
1.1.6	Бараа материал	438 181 461.30	457 739 622.20
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	428 482 728.40	462 473 248.30
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	3 843 552.60	4 296 075.10
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	7 574 237.20	10 785 904.60
1.1.10		0.00	1 276 065.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1 408 857 609.50	1 448 219 141.00
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.1	Үндсэн хөрөнгө	2 193 843 905.30	2 238 060 135.70
1.2.2	Биет бус хөрөнгө	29 420 476.20	27 453 939.10
1.2.3	Биологийн хөрөнгө	2 372 070.20	2 372 889.50
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	187 730 552.60	187 659 457.40
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	1 778 083.50	2 037 757.20
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	8 659 925.80	10 611 428.40
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	5 988 991.00	5 609 356.70
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	181 482 109.80	204 722 382.20
1.2.9		5 569 480.50	6 191 474.40
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2 616 845 594.90	2 684 718 820.60
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4 025 703 204.40	4 132 937 961.60
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	0.00	0.00
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	302 946 730.80	310 798 932.60
2.1.1.2	Цалингийн өглөг	6 765 878.60	8 620 940.90
2.1.1.3	Татварын өр	32 303 998.40	43 542 411.80
2.1.1.4	НДШ - ийн өглөг	7 336 459.10	12 507 163.20
2.1.1.5	Банкны богино хугацаат зээл	174 313 316.60	155 066 168.60
2.1.1.6	Хүүний өглөг	11 749 632.80	12 907 531.80
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	21 229 314.00	30 088 131.80
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	34 983 698.00	42 659 257.80
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	2 789 559.30	2 893 289.50
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	55 073 557.40	57 975 138.90
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр	0.00	0.00
2.1.1.12		39 341.90	48 927.80
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	649 531 486.90	677 107 894.70
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.1	Урт хугацаат зээл	822 001 893.90	799 373 560.10

СЗХ | Зохицуулалтын салбарын нэгдсэн тойм

2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	26 770 282.00	27 447 950.40
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	641 504.70	1 254 632.40
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	254 940 418.80	262 289 615.70
2.1.2.5		10 937 373.20	9 903 429.80
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	1 115 291 472.60	1 100 269 188.40
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1 764 822 959.50	1 777 377 083.10
	Эздийн өмч		
2.3	Өмч	811 415 310.10	911 862 292.40
2.3.1	- төрийн	631 533 237.00	714 051 492.10
2.3.2	- хувийн	54 205 934.30	49 853 612.50
2.3.3	- хувьцаат	125 676 138.80	147 957 187.80
2.3.4	Халаасны хувьцаа	419 836.50	405 977.50
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	62 624 577.50	56 970 331.30
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	720 647 362.20	730 253 137.40
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	202 013.50	203 111.20
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	635 861 195.60	644 998 194.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	30 549 622.50	11 646 482.50
2.3.10		0.00	0.00
2.3.11	Эздийн өмчийн дүн	2 261 719 917.90	2 356 339 526.30
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	4 026 542 877.40	4 133 716 609.40

2. Хувьцаат компанийн орлого, үр дүн

Нийт 177 хувьцаат компани /мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1 829 662 705.00	938 234 284.30
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1 570 319 906.80	803 353 150.30
3	Нийт ашиг (алдагдал)	259 037 734.60	134 881 134.00
4	Түрээсийн орлого	9 804 258.80	6 543 199.00
5	Хүүний орлого	5 203 307.60	2 371 090.60
6	Ногдол ашгийн орлого	1 580 795.20	277 897.50
7	Эрхийн шимтгэлийн орлого	366 551.80	22 577.10
8	Бусад орлого	45 310 808.70	17 429 509.50
9	Борлуулалт, маркетингийн зардал	76 538 598.80	32 879 975.10
10	Ерөнхий ба удирдлагын зардал	163 852 178.60	82 292 815.10
11	Санхүүгийн зардал	21 777 071.70	12 890 754.50
12	Бусад зардал	40 040 187.20	15 906 340.40
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-27 492 713.00	-10 268 688.50
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-11 415 711.50	-437 102.40
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	1 822.90	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	208 011.10	-16 094.10
17	Бусад ашиг (алдагдал)	-4 258 773.90	98 200.60
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-23 556 880.40	6 931 838.20
19	Орлогын татварын зардал	7 254 573.40	3 439 244.10
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-30 811 453.80	3 492 594.10
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0.00	0.00

СЗХ | Зохицуулалтын салбарын нэгдсэн тойм

22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-30 811 453.80	3 492 594.10
23	Бусад дэлгэрэнгүй орлого	46 924.50	3 296.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	46 924.50	3 296.00
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	-30 764 529.30	3 534 007.80
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-11.60	4.90

3. Үнэт цаасны компаниудын санхүүгийн байдал

Нийт 48 үнэт цаасны компани /мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Өмнөх үе	Тайлант үе
1	Хөрөнгө	4 156 995 810.18	3 719 505 721.583
1.1	Эргэлтийн хөрөнгө	4 035 147 475.11	3 571 756 333.157
1.1.1	Мөнгөн хөрөнгө	1 141 117 336.12	876 018 711.90
1.1.1.1	Бэлэн мөнгө	105 476 460.94	98 426 898.69
1.1.1.2	Банкан дахь харилцах	754 989 929.76	387 482 379.88
1.1.1.3	Банкинд байршуулсан хадгаламж	280 650 945.41	390 109 433.32
1.1.2	Богино хугацаат хөрөнгө оруулалт	403 712 453.85	327 779 228.61
1.1.2.1	Хувьцаа	283 369 413.13	195 691 036 .81
1.1.2.2	Бонд	128 077 415.00	139 076 582.94
1.1.2.3	Үнэт цаасны бодит үнэ цэнийн тохируулга /+,-/	-7 734 374.29	-6 988 391.14
1.1.3	Авлага	2 475 856 794.64	2 336 013 279.77
1.1.3.1	Дансны авлага	2 403 373 386.74	2 244 944 436.14
1.1.3.2	Найдваргүй авлагын хасагдуулга	-47 802 724.96	-56 976 378.19
1.1.3.3	Бусад авлага	120 286 132.86	148 073 594.08
1.1.4	Бараа материал	1 688 921.90	1 805 925.25
1.1.4.1	Бараа материал	1 688 921.90	1 805 925.25
1.1.5	Мал амьтад	0.00	0.00
1.1.6	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	241 868.78	333 782.02
1.1.7	Бусад	13 446 425.42	31 625 954.03
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	121 848 335.07	147 749 388.42
1.2.1	Үндсэн хөрөнгө	98 983 114.75	97 536 100.19
1.2.2	Хуримтлагдсан элэгдэл	1 401 601.20	1 725 999.14
1.2.3	Бусад үндсэн хөрөнгө	892 322.18	903 804.70
1.2.4	Хуримтлагдсан элэгдэл	262 524.84	288 835.64
1.2.5	Дуусаагүй барилга	0.00	0.00
1.2.6	Мал амьтад (ХАА-н үйлдвэрлэлийн)	0.00	0.00
1.2.7	Биет бус хөрөнгө	6 555 716.89	7 073 779.92
1.2.8	Хуримтлагдсан элэгдэл	13 225.70	31 460.16
1.2.9	Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө	13 898 693.27	13 955 522.35
1.2.10	Үнэлгээний хасагдуулга	0.00	0.00
1.2.11	Бусад	3 195 839.72	30 326 476.19
2	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч	4 156 972 615.17	3 719 477 933.83
2.1	Өр төлбөр	3 712 136 833.68	3 261 562 320.16
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	2 624 257 836.06	2 338 996 002.765.45
2.1.2	Дансны өглөг	2 437 597 991.72	2 096 069 871.58
2.1.3	Цалингийн өглөг	150 083.62	170 921.77
2.1.4	Орлогын татварын өглөг	5 833 480.27	807 132.58
2.1.5	ХАОТ-ын өглөг	42 206.27	42 764.37
2.1.6	НӨАТ-ын өглөг	10 373.94	2 063.04
2.1.7	Бусад татварын өглөг	28 233.37	8 997.27

СЗХ | Зохицуулалтын салбарын нэгдсэн тойм

2.1.8	ЭМНД-ийн өглөг	4 842.56	7 400.73
2.1.9	Ногдол ашгийн өглөг	988 164.78	596 319.96
2.1.10	Банкны богино хугацаат зээл	133 287 187.09	186 930 714.74
2.1.11	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	44 870 202.09	52 428 987.92
2.1.12	Бусад өглөг	1 353 836.00	1 856 801.68
2.1.13	Урдчилж орсон орлого	91 234.31	74 027.05
2.2	Урт хугацаат өр төлбөр	1 088 095 228.24	922 749 602.85
2.2.1	Урт хугацаат векселийн өглөг	0.00	0.00
2.2.2	Урт хугацаат зээл	1 077 739 308.30	912 167 595.88
2.2.3	Урт хугацаат бондын өглөг	0.00	0.00
2.2.4	Бусад урт хугацааны өглөг	10 355 919.93	10 582 006.96
2.2.5	Урт хугацаат өглөгийн хасагдуулга	0.00	0.00
2.3	Эзэмшигчдийн өмч	444 835 781.48	457 915 613.66
2.3.1	Өмч: Төрийн өмч	1 635 554.20	1 635 554.20
2.3.2	Хувийн өмч	85 414 301.54	87 772 700.72
2.3.3	Халаасны хувьцаа	0.00	0.00
2.3.4	Хувьцаат капиталын дүн	87 049 855.74	89 408 254.92
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	52 881 871.69	52 882 258.39
2.3.6	Дахин үнэлгээний нөөц	9 644 372.33	9 329 608.08
2.3.7	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	67 947 882.00	71 239 676.95
2.3.8	Үнэт цаасны хэрэгжээгүй олз, гарз	-84 572.12	55 088.44
2.3.9	Эрсдлийн сан	412 015.99	412 015.99
2.3.10	Хуримтлагдсан ашиг, алдагдал	227 707 645.64	236 260 270.00
2.3.11	Тайлангийн үеийн	50 650 017.81	8 033 481.81
2.3.12	Өмнөх үеийн	177 057 627.82	228 248 651.85
2.3.13	Үүнээс: цөөнхийн хувь оролцоо	0.00	0.00

4. Үнэт цаасны компаниудын орлого, үр дүн

Нийт 48 үнэт цаасны компани /мянган төгрөг/

№	Үзүүлэлт	НИЙТ
1.1	Үндсэн үйл ажиллагааны орлого	173 276 041.01
1.2	Үйл ажиллагааны орлого	2 534 837.76
1.3	Брокер, дилерийн үйл ажиллагааны	1 750 623.72
1.4	Андеррайтерийн үйл ажиллагааны	357 080.19
1.5	Хөрөнгө оруулалт менежмент хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээний	427 133.84
1.6	Хөрөнгө оруулалтын орлого	84 892 163.86
1.7	Хүүгийн орлого	79 383 863.10
1.8	Арилжаалсан үнэт цаасны орлого	5 503 953.76
1.9	Ноогдол ашгийн орлого	4 346.99
1.10	Бусад	85 849 039.39
1.11	Борлуулалтын хөнгөлөлт	0.00
1.12	Борлуулалтын хорогдол ба буцаалт	0.00
1.13	Үндсэн үйл ажиллагааны цэвэр борлуулалтын орлогын дүн	173 276 041.01
2	Борлуулсан үнэт цаасны өртөг	227 292.08
3	Нийт ашиг (алдагдал)	173 048 748.93
4.1	Үйл ажиллагаа (борлуулалт, ерөнхий удирдлага)-ны зардал	164 410 268.69
4.2	Үндсэн болон нэмэгдэл цалин	7 035 182.79
4.3	Нийгмийн даатгалын шимтгэл	756 118.58
4.4	Засвар үйлчилгээний зардал	572 240.29
4.5	Ашиглалтын зардал	300 523.10
4.6	Түрээсийн зардал	2 336 486.27
4.7	Албан томилолтын зардал	230 132.89
4.8	Тээврийн зардал	6 529.45

СЗХ | Зохицуулалтын салбарын нэгдсэн тойм

4.9	Түүхий эд материалын зардал	264 948.47
4.10	Элэгдлийн зардал	3 093 381.81
4.11	Зар сурталчилгааны зардал	396 826.93
4.12	Шуудан холбооны зардал	344 845.93
4.13	Шатхууны зардал	331 814.77
4.14	Найдваргүй авлагын зардал	19 492 008.88
4.15	Шагнал урамшууллын зардал	9 057.33
4.16	Зээлийн хүүгийн зардал	53 641 799.92
4.17	Зохицуулах хорооны зохицуулалтын үйлчилгээний хөлс	45 201.39
4.18	Биржийн гишүүн хураамж	51 324.20
4.19	ҮЦТГТХТ-ийн үйлчилгээний хураамж	7 359.50
4.20	Шимтгэл	83 697.55
4.21	Зохицуулалтын үйлчилгээний хураамж	6 484.80
4.22	Хөрөнгийн биржийн шимтгэл	48 381.58
4.23	ҮЦТГТХТ-ийн шимтгэл	31 834.72
4.24	Бусад зардал	75 407 785.01
5.1	Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)	8 638 480.23
5.2	Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)	-58 304.09
5.3	Үндсэн бус үйлдвэрлэл, үйлчилгээний ашиг, алдагдал	-8.50
5.4	Торгууль, хөнгөлөлт ашиг (алдагдал)	1 462.62
5.5	Эрсдлийн сангийн зардал	-473.38
5.6	Валютын ханшийн өөрчлөлтийн хэрэгжсэн ашиг (алдагдал)	13 600.51
5.7	Валютын ханшийн өөрчлөлтийн хэрэгжээгүй ашиг (алдагдал)	-71 578.28
5.8	Хувьцаа, бондын зардлын хорогдуулга	4 765.20
5.9	Хараат болон хамтарсан үйлдвэрээс олсон ашиг	959.51
5.10	Бусад	-7 164.27
6.1	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	8 580 176.14
6.2	Орлогын татварын зардал	141 413.62
6.3	Татварын дараах ашиг (алдагдал)	8 438 762.51
6.4	Цөөнхөд ноогдох хувь	0.00
6.5	Ердийн үйл ажиллагааны ашиг (алдагдал)	8 438 762.51
6.6	Онцгой шинжтэй зүйл - цэвэр	0.00
6.7	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	8 488 821.23
6.8	Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал)	0.00

Хавсралт 2. Хөдөө аж ахуйн биржийн мэргэжлийн оролцогчдын 2015 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэл

1. Санхүүгийн байдлын тайлан

ХАА-н биржийн зуучлагч нийт 37 компани /мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2 596 683.93	4 319 971.58
1.1.2	Дансны авлага	2 461 465.65	2 449 919.01
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	3 190.10	1 647.76
1.1.4	Бусад авлага	862 694.95	857 635.61
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.6	Бараа материал	6 615.70	242 853.60
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	15 469.80	34 119.80

СЗХ | Зохицуулалтын салбарын нэгдсэн тойм

1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	617.70	1 598.70
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	0.00	0.00
1.1.10	Эргэлтийн хөрөнгийн дүн	5 946 737.84	7 907 746.08
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	388 327.77	369 418.36
1.2.2	Биет бус хөрөнгө	2 486.47	2 933.17
1.2.3	Биологийн хөрөнгө	0.00	0.00
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	0.00	0.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0.00	0.00
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	0.00	0.00
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.00	0.00
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	0.00	1 000.00
1.2.9	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	390 814.24	373 351.53
1.3	Нийт хөрөнгийн дүн	6 102 616.48	7 843 162.01
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.2	Дансны өглөг	144 866.86	236 285.16
2.1.3	Цалингийн өглөг	3 843.16	17 954.60
2.1.4	Татварын өр	5 888.14	8 933.15
2.1.5	НДШ -ийн өглөг	8 163.14	3 332.49
2.1.6	Банкны богино хугацаат зээл	0.00	0.00
2.1.7	Хүүний өглөг	0.00	0.00
2.1.8	Ногдол ашгийн өглөг	0.00	0.00
2.1.9	Урьдчилж орсон орлого	0.00	0.00
2.1.10	Нөөц/өр төлбөр/	0.00	0.00
2.1.11	Бусад богино хугацаат өр төлбөр	64 708.66	97 018.15
2.1.12	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө(борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр	0.00	0.00
2.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	227 469.98	363 523.57
2.1.2	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
